

МОНГОЛ УЛС ДАХЬ ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ПРОЦЕССЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

П.Баярцэцэг (LL. M)

*Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн
шүүхийн сургалт хариуцсан ахлах референт, судлаач*

Удиртгал

Хууль дээдлэх ёсыг төлөвшүүлж, ардчиллыг бэхжүүлэн, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгыг дэвшүүлсэн аль ч нийгэмд шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх үндсэн хуулийн зарчим үйлчилдэг. Хүний амь нас, эрх, эрх чөлөө, өмч хөрөнгө зэрэг амин чухал ашиг сонирхлыг хөндсөн шийдвэр гаргах эрхтэй шүүгчдэд энэ эрхэм бөгөөд хариуцлагатай чиг үүргээ төвийг сахиж, шударгаар хэрэгжүүлэх нөхцлийг нь бүрдүүлэхийн тулд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал гэсэн баталгааг бүрдүүлдэг. Харин шүүгчид гагцхүү хуульд захирагдах үндсэн зарчмаа зөрчиж ёс зүйн ноцтой зөрчил гарган олон нийтийн итгэлийг хөсөрдүүлж эхэлбэл тухайн зөрчлийг шалгаж, тогтоох, нотлох, шийдвэрлэх ажиллагаа шударга, үр нөлөөтэй байх шаардлагатай. Энэ өгүүлээр шүүгчийн сахилгын процессын ойлголт, мөн чанар, олон улсын жишиг сайн туршлагыг судлан тогтоосны үндсэн дээр Монгол Улс дахь шүүгчийн сахилгын процессын тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг дэвшүүлнэ.

НЭГ. ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ПРОЦЕССЫН ҮНДСЭН АСУУДАЛ

Энэ хэсэгт шүүгчийн сахилгын процессын үндсэн асуудлыг авч үзэхдээ шүүгчийн сахилгын тухай үндсэн ойлголтыг тодорхойлж, олон улсын зөвлөмжийн шинжтэй баримт бичиг, судалгааны тайлан зэрэгт тулгуурлан шүүгчийн сахилгын сахилгын процессын загвар, онцлог, нийтлэг болон ялгаатай талыг танилцуулахын зэрэгцээ шүүгчийн сахилгын процессын материаллаг хэм хэмжээ, сахилгын хэргийг шийдвэрлэх институт, сахилгын хэрэг шийдвэрлэх ажиллагаа гэсэн хүрээнд нийтлэг жишгийг тодорхойлно.

1.1. Шүүгчийн сахилгын процессын тухай үндсэн ойлголт

Шүүгч гагцхүү хуульд захирагдан, өргөсөн тангарагтаа үнэнч байж, албан үүргээ хэний ч нөлөөнд авталгүй хариуцлагатай хэрэгжүүлснээр шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хадгалж байдаг. Хариуцлагатай, мэргэшсэн шүүх эрх мэдэл нь өөрийн шударга үйл ажиллагаагаар олон нийтийн итгэл, хүндлэлийг хүлээдэг бол олон нийтийн тэрхүү итгэл нь шүүх эрх мэдлээ бие даасан, шүүгчийг хараат бус ажиллуулах зарчимч шаардлагыг тавьдаг.¹ Харин шүүгчид албаны болон хувийн амьдралд баримтлах хэм хэмжээ, стандартыг зөрчиж, үүрэг, хариуцлагаа умартаж, ёс зүйн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд тухайн зөрчлийг шалгаж тогтоох, шийдвэрлэх ажиллагаа зайлшгүй бөгөөд шударга байх ёстой. Шүүгчийн гаргасан ёс зүйн зөрчлийг шалгах, тогтоох, нотлох, шийдвэрлэх ажиллагааг олон улсад “Шүүгчийн сахилгын процесс” (Judicial Disciplinary Procedure) гэж нэрлэдэг. Шүүгчийн сахилгын процессын гол зорилго нь ёс зүйн

¹ Т.Вайт, “Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд шүүхийн захиргааны гүйцэтгэх үүрэг”, “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд шүүхийн захиргааны үүрэг” олон улсын онол, практикийн бага хурлын илтгэлийн эмхэтгэл, Шүүхийн ерөнхий зөвлөл, УБ, 2013, 19 дэх тал

ноцтой зөрчил гаргасан шүүгчийг цээрлүүлж, шийтгэхэд бус, харин нийтийн ашиг сонирхол, хүний эрхийг хамгаалахад орших² бөгөөд хувийн болон нийтийн ашиг сонирхлын аль аль нь хөндөгддөг хосолмол шинж бүхий онцлог процесс юм.

Шүүгчийн сахилгын процессыг эрүү, иргэн, захиргааны зэрэг процессын эрх зүйд хамаатуулах холимог хандлага зарим улсад байдаг.³ Олон улсын шүүгчдийн холбооноос гаргасан Шүүгчийн түгээмэл дүрэм (The Universal Charter of the Judge) –д “Шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх аливаа ажиллагааг шүүгчийн хараат бус байдалд халдахгүй хэлбэрээр явуулах бөгөөд бодит байдлыг бүрэн тогтоох зорилготой байна⁴ гэсэн байна. Эндээс үзвэл шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны бодит байдлыг бүрэн тогтоох зорилгыг хэрэгжүүлэхэд талуудын санаачилгаар гэхээс илүүтэй мөрдөн шалгах, шийдвэрлэх байгууллага хөтөлж явуулдаг болохыг дараах нийтлэг шинжээр тогтоож болохоор байна: (1) Хөндөгдөж байгаа ашиг сонирхлын хувьд шүүхэд итгэх олон нийтийн итгэл, шударгаар шүүлгэх иргэний эрх зэрэг нийтийн ашиг сонирхол байдаг, (2) Сахилгын хэргийг шалгах, нотлох зэрэг чиг үүрэг талуудад бус, харин хараат бус, бие даасан сахилгын хороо зэрэг байгууллагад байдаг, (3) Шүүгчийн сахилгын хэргийг шалгах ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдийн гаргасан гомдол, мэдээллээс гадна сахилгын хэргийг шалгах эрхтэй субъектын санаачилгаар эхэлдэг зэрэг болно.

1.2. Шүүгчийн сахилгын процессын загвар

Аливаа тогтолцоо, процесс, хэм хэмжээг загвар, ангилалд хуваан судлах нь тухайн асуудлыг системтэйгээр танин мэдэх, нийтлэг тал болон ялгаа, давуу болон сул талыг нарийвчлан тодруулахад ач холбогдолтой. Олон улсын зөвлөмжийн шинжтэй баримт бичиг, судалгааны тайлан зэрэгт тулгуурлан шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дараах гурван ангиллаар загварт хувааж болно:

А. Эрх зүйн тогтолцооны ангилал:⁵ 1) эх газрын эрх зүйн тогтолцоо, 2) нийтлэг эрх зүйн тогтолцоо;

Б. Сахилгын хэргийг шийдвэрлэдэг субъектын ангилал:⁶ 1) Шүүхийн зөвлөл, 2) Шүүхийн зөвлөлөөс тусдаа бие даасан субъект (Зөвлөл, хороо г.м), 3) Шүүх;

В. Сахилгын хэргийг шалгах, нотлох, хянах, шийдвэрлэх чиг үүргийн төвлөрлийн ангилал:⁷ 1) чиг үүргийг бүрэн бүрэн тусгаарласан, 2) мөрдөн шалгах болон шийдвэрлэх чиг үүргийг тусгаарласан, 3) нэг субъектэд төвлөрүүлсэн загвар зэрэг болно.

А. Эрх зүйн тогтолцооны ангилал

² Cynthia Gray, “How Judicial Conduct Commissions Work,” *The Justice System Journal*, Vol. 28, No. 3 (2007). 405.

³ Florence R. Peskoe, “Procedures for Judicial Discipline: Type of Commission, Due Process & (and) Right to Counsel,” *Chi.-Kent. L. Rev.* 147 (1977): 157.

⁴ Олон улсын шүүгчдийн холбооны Төв зөвлөлийн 1999 оны 11 сарын 17-ны өдрийн хуралдаанаар тус зөвлөмжийн шинжтэй баримт бичгийг батлан гаргасан бөгөөд тухайн үед гишүүн байсан 42 орон дэмжин баталсан байна. The Universal Charter of the Judge, (International Association of Judges in Taipei on November 17, 1999) accessed April 09, 2016, <https://www.domstol.dk/om/otherlanguages/english/publications/Publications/The%20universal%20charter%20of%20the%20judge.pdf>

⁵ United Nations Office On Drugs and Crime, Resource Guide on Strengthening Judicial Integrity and Capacity, (New York, 2011), 132.

⁶ European Network of Councils for the Judiciary, Minimum Judicial Standards V: Disciplinary Proceedings and Liability of Judges Report, 32.

⁷ О.Мөнхсайхан, Г.Цагаанбаяр, Ж.Алтансүх, *Монгол Улс дахь Шүүхийн захиргааны загвар: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам*, (УБ: Нээлттэй нийгэм форум, 2015), 129.

Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нийтлэг болон эх газрын гэсэн эрх зүйн тогтолцоогоор ангилах энэ ангиллыг НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газраас гаргасан “Шүүх эрх мэдлийн чадавх, шударга байдлыг бэхжүүлэх гарын авлага”-д ашигласан бөгөөд сахилгын процессын ерөнхий ойлголт өгөх ач холбогдолтой.

1) *Нийтлэг эрх зүйн тогтолцоо*: Нийтлэг эрх зүйн тогтолцооны төлөөлөгч АНУ-ын тухайд 1960 онд Калифорни мужид анхлан шүүгчийн сахилгын тогтолцоог бий болгосноос хойш өдгөө муж тус бүр өөрийн онцлог бүхий сахилгын тогтолцоог төлөвшүүлжээ.⁸ Мужуудын түвшинд шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийг батлан гаргах бөгөөд дүрмийг гол төлөв шүүгч, хуульч, нэр хүндтэй иргэдийн жигд төлөөллөөс бүрдсэн шүүгчийн сахилгын байгууллагаас хэрэглэж, сахилгын зөрчлийг шийдвэрлэдэг.⁹ Эдгээр байгууллага нь шүүгчийн сахилгын зөрчлийн талаар иргэдээс ирүүлсэн гомдол эсхүл өөрийн санаачилгаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхтэй бөгөөд хагас шүүхийн хэлбэрээр ажилладаг.¹⁰

2) *Эх газрын эрх зүйн тогтолцоо*: Энэ тогтолцооны улс орнуудын хувьд шүүгчид холбогдуулан сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэргийг шалгах, шийдвэрлэх субъект, бүрэлдэхүүн, сахилгын шийтгэлийн төрөл зэргээр өөр хоорондоо харилцан адилгүй боловч дараах асуудлаар нэгтгэн харж болно.¹¹ Сахилгын хэрэг үүсгэх эрх бүхий субъектын хувьд Хууль зүйн сайд, Ерөнхий прокурор зэрэг субъект өргөн хүрээнд оролцдог. Тухайлбал, Италид хяналтын шатны шүүхийн Ерөнхий прокурор,¹² Францад давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, Хууль зүйн сайд¹³ зэрэг субъект сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэдэг. Сахилгын хэргийг шийдвэрлэх чиг үүргийг Итали, Франц зэрэг улсад Шүүхийн дээд зөвлөл хэрэгжүүлэх бол Польш улсад сахилгын шүүх хэрэгжүүлдэг. Эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудын хувьд шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэхэд иргэдийн оролцоо хязгаарлагдмал бөгөөд шүүгчийн сахилга, ёс зүйн зөрчлийн талаар иргэд гомдол гаргах албан ёсны механизм төдийлөн байхгүй.¹⁴ Өөрөөр хэлбэл, гомдлоор хэрэг үүсгэх боломж хязгаарлагдмал бөгөөд харин иргэд сахилгын хэрэг үүсгэх эрх бүхий албан тушаалтанд энэ тухай мэдээлэх боломжтой. Энэ нь сахилгын хэрэг үүсгэх эрх бүхий субъектын бие даасан байдал хангагдсан, шударгаар шийдвэрлэх соёл төлөвшсөн нөхцөлд хэрэгжих боломжтой бол ийм соёл, баталгаа төлөвшөөгүй нөхцөлд сул тал болон хувирах эрсдэлтэй.

Б. Сахилгын хэргийг хянан шийдвэрлэдэг субъектын ангилал

1) *Шүүхийн зөвлөл шийдвэрлэдэг загвар*: Дэлхийн олон улс оронд шүүхийн зөвлөл хэмээх институтыг байгуулах үзэгдэл ажиглагдаж байгаа бөгөөд эдгээр зөвлөл нь шүүгчид асуудлаа дотооддоо бие даан шийдвэрлэх боломжийг олгох, шүүгчийн томилгоо, сахилга хариуцлагын асуудлыг улс төрийн болон хөндлөнгийн нөлөөнөөс хамааралгүйгээр шийдвэрлэх нөхцлийг

⁸ Florence R. Peskoe, “Procedures for Judicial Discipline: Type of Commission, Due Process & (and) Right to Counsel,” *Chi.-Kent. L. Rev.* 147 (1977), 1.

⁹ United Nations Office On Drugs and Crime, Resource Guide on Strengthening Judicial Integrity and Capacity, (New York, 2011), 132.

¹⁰ Хагас шүүхийн байгууллага (Quasi-judicial body) гэдэг нь тодорхой маргааны үйл баримтыг тогтоох, хууль зүйн дүгнэлт гаргах, шүүхийн адил дотоод итгэл үнэмшлээр шийдвэр гаргах бүрэн эрхтэй байгууллага юм. Шүүхээс ялгаатай нь нотлох баримтын хатуу журам баримталдаггүй зэрэг онцлогтой. <https://www.law.cornell.edu/wex/quasi-judicial>

¹¹ United Nation’s Office for Drug and Crimes, Resource Guide on Strengthening Judicial Integrity and Capacity, 133.

¹² Мөн тэнд.

¹³ Франц улсын Шүүхийн тухай хуулийн 43 дугаар зүйл.

¹⁴ Мөн тэнд.

бүрдүүлэх үндсэн зорилготой.¹⁵ Зарим улсын шүүхийн зөвлөл нь шүүгчийн томилгоо, шүүгчийн сахилгын зэрэг өргөн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бол Швед, Дани зэрэг оронд эдгээр зөвлөл нь шүүхийн төсөв санхүү, шүүгчийн сургалт, захиргаа, зохион байгуулалт, менежментийн зэрэг хязгаарлагдмал чиг үүрэгтэй.¹⁶ Харин Албани, Болгар, Хорват, Франц, Итали, Португаль, Румын, Испани, Турк зэрэг улс оронд шүүхийн хүний нөөцийн чиглэлээр ялангуяа шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо, сахилга хариуцлага, огцруулах зэрэг чиг үүргийг төвлөрүүлсэн шүүхийн зөвлөл ажилладаг.¹⁷ Энэ загварын хувьд тухайн шүүхийн зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний бие даасан байдлыг хэрхэн тогтоосноос шүүгчийн хараат бус болон хариуцлагатай байдлыг хангах гэсэн сахилгын процессын хоёр зорилго хангагдах эсэх нь шууд хамаарч байдаг онцлогтой. Өөрөөр хэлбэл, шүүгчийн сахилгыг сахиулах шударга тогтолцоо бий болох эсэх нь цэвэр шүүхийн зөвлөлийн бүрэн эрх, чиг үүрэг, бүрэлдэхүүнээс хамаарах бөгөөд шүүгчийн хараат бус байдлыг хүндэтгэх төвшин хийгээд эрх зүйн соёл өндөр хөгжсөн улс орнуудад тохирох загвар юм.

2) *Шүүхийн зөвлөлөөс тусдаа бие даасан субъект шийдвэрлэдэг загвар*: Энэ загвар дахь улс орнуудад шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэдэг нийтлэг субъект нь бие даасан, хамтын зарчмаар ажилладаг хороо, комисс, зөвлөл зэрэг хэлбэртэй байгууллага байдаг.¹⁸ Шүүхийн зөвлөлөөс тусдаа бие даасан субъект шийдвэрлэх нь шүүхийн захиргааны хүний нөөцийн чиг үүргийн төвлөрлийг багасгадаг, шүүхийн захиргаанаас харьцангуй хараат бус, чиг үүргийн хувьд дагнан мэргэших боломжийг олгодог зэрэг давуу талтай. Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүн, томилгоо, үйл ажиллагааны хараат бус байдлыг бүрдүүлэхэд төрийн бусад эрх мэдлээс хараат бус байлгах, бүрэлдэхүүнд шүүгчид болон олон нийт, хуульчдын төлөөллийг харилцан тэнцвэртэй оруулах нь өмнөх загварын адил үр нөлөө бүхий сахилгын тогтолцоо бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

3) *Сахилгын хэргийг шүүх шийдвэрлэдэг загвар*: Сахилгын хэргийг шийдвэрлэдэг субъектын ангиллын гурав дахь нь шүүгчийн сахилгын хэргийг шүүх шийдвэрлэдэг загвар юм. Сахилгын хэргийг шийдвэрлэх шүүх нь тухайн шүүх дэх сахилгын бүрэлдэхүүн эсхүл тусгайлан байгуулсан сахилгын шүүх зэрэг байж болох¹⁹ бөгөөд Польш, Словени, Унгар зэрэг хэд хэдэн оронд бий. Шүүгчийн сахилгын хэргийг шүүгчид өөрсдөө бие даан шийдвэрлэдэг энэ хувилбар амжилттай хэрэгжих эсэх нь шүүгчийн ёс зүй өндөр түвшинд хүрсэн, шүүгч шүүгчийнхээ явцуу ашиг сонирхлыг хамгаалдаг хандлага тогтоогүй, шүүгчийн тоо, үйл ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэрийн байршил зэрэг хүчин зүйлсээс хамааралтай.

В.Сахилгын хэрэг шалгах, нотлох, хянах, шийдвэрлэх чиг үүргийн төвлөрлийн ангилал²⁰

Сахилгын процессын гурав дахь ангилал нь шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөрдөн шалгах, нотлох, хяналт тавих, шийдвэрлэх гэсэн чиг үүргийг ямар субъектэд харьяалуулсан гэдгээс хамаарч загварт хуваадаг ангилал юм. Доктор О.Мөнхсайхан

¹⁵ Nuno Garoupa and Tom Ginsburg, "Guarding the Guardians: Judicial Councils and Judicial Independence," *Law and Economics Working Paper*, No. 444 (2008):2.

¹⁶ Prof. Wim Voermans and Dr. Pim Albers, *Councils for the Judiciary in EU Countries*, European Commission for the Efficiency of Justice, (European Commission for the Efficiency of Justice 2003), 9.

¹⁷ Esterling K. M, "Judicial Accountability the Right Way: Official performance evaluations help the electorate as well as the bench," *in Judicature*, Vol. 82, no. 5 (2006):215.

¹⁸ Cynthia Gray, *How Judicial Conduct Commissions Work*, 405.

¹⁹ European Network of Councils for the Judiciary, Minimum Judicial Standards V: Disciplinary Proceedings and Liability of Judges, 33.

²⁰ О.Мөнхсайхан нар, *Монгол Улс дахь Шүүхийн захиргааны загвар: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам*, 129.

нар энэ ангиллаар шүүхийн сахилгын процессыг 1) Америк маягийн загвар буюу мөрдөн шалгах, нотлох, түүнд хяналт тавих, шийдвэрлэх гэсэн 4 чиг үүргийг салгасан загвар, 2) Европын холбооны улсуудын буюу загвар буюу ёс зүйн асуудлыг мөрдөн шалгах, шийдвэрлэх гэсэн 2 үндсэн чиг үүрэгт салгасан загвар, 3) Монгол Улсын одоогийн тогтолцоо шиг шүүхийн сахилгын хорооны гишүүн бүх чиг үүргийг хэрэгжүүлдэг загвар²¹ гэж ангилжээ. Энэхүү ангиллын загваруудыг онцлог, ялгааг товчхон тодорхойлвол:

1) *Нэг субъектэд төвлөрүүлсэн загвар*: Сахилгын процесст чиг үүргийг хуваарилаагүй буюу мөрдөн шалгах, нотлох, хяналт тавих, шийдвэрлэх гэсэн чиг үүргийг ямар нэгэн субъектэд хуваарилаагүй загвар. Тухайн сахилгын хэргийг гардан шалгасан, шалгахад байлцсан, тодорхой ажиллагаанд зөвшөөрөл олгосон, хяналт тавьсан субъект сахилгын хэрэг шийдвэрлэхэд саналын эрхтэйгээр оролцдог эсхүл дангаар шийдвэрлэдэг. Энэ загварын жишээ нь Франц, Монгол зэрэг улс юм. Тухайлбал, Францад шүүгч өөрийн албан тушаалаар хүлээсэн үүрэг, шүүгчийн өндөр нэр хүндийг зөрчсөн бол Хууль зүйн сайд, давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор зэрэг албан тушаалтан сахилгын хэрэг үүсгэн²² Шүүхийн дээд зөвлөлд хүргүүлэх бөгөөд Зөвлөлөөс аль нэг гишүүнээ мөрдөн шалгалт явуулж танилцуулахаар хуваарилна.²³ Сахилгын хэргийг шалгасан гишүүн шийдвэрлэх бүрэлдэхүүнд орохыг хориглосон зохицуулалт байдаггүй. Мөрдөн шалгах ажиллагаа дуусмагц шүүгчийн сахилгын хэргийг Зөвлөлийн нээлттэй хуралдаанаар хянан шийдвэрлэнэ. Мөрдөн шалгах, шийдвэрлэх чиг үүргийг салгадаггүй энэ загварыг олон улсад төдийлөн зөвлөдөггүй.

2) *Мөрдөн шалгах болон шийдвэрлэх чиг үүргийг тусгаарласан загвар*: Энэ загварын хувьд сахилгын хэргийг шалгах, шийдвэрлэх гэсэн хоёр чиг үүргийг тусгаарлаж, өөр өөр субъектэд хариуцуулдаг. Процессын шударга ёсны зарчмыг зөрчихгүй бөгөөд Польш, Испани зэрэг гол төлөв Европын хэд хэдэн оронд бий. Тухайлбал, Польш улсад шүүгчийн ёс зүйн зөрчилд холбогдуулан сахилгын хэрэг үүсгэх, мөрдөн шалгах чиг үүргийг Сахилгын төлөөлөгч (Disciplinary Commissioner)²⁴, шийдвэрлэх чиг үүргийг Сахилгын шүүх (Disciplinary Court) хэрэгжүүлдэг. Энэ загварын хувьд өмнөх бүрэн тусгаарласан загвар шиг сахилгын процессын чиг үүрэг бүрийг тусгаарладаггүй бөгөөд наад зах нь мөрдөн шалгах, шийдвэрлэх гэсэн хоёр чиг үүргийг тусгаарлах ёстой бөгөөд энэ нь “жижиг” улс орнуудад илүү тохирно²⁵ гэж үздэг.

3) *Чиг үүргийг бүрэн тусгаарласан загвар*: Энэ загварын гол онцлог нь сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг мөрдөн шалгах, нотлох, хяналт тавих, шийдвэрлэх гэсэн 4 чиг үүргийг эрүүгийн процесстэй нэгэн адилаар салган хуваарилж, өөр өөр субъект хэрэгжүүлдэг бөгөөд АНУ-ын ихэнхи мужид бий. Ингэснээр нэг ажиллагаанд оролцсон буюу тухайн зөрчлийн талаар урьдчилсан төсөөлөлтэй болсон субъект тухайн зөрчлийг хянан шийдвэрлэхэд оролцох бололцоог хязгаарладаг.²⁶ Тухайлбал, Америкийн Хуульчдын холбооноос гаргасан Шүүгчийн сахилгыг сахиулах загвар дүрэмд зааснаар сахилгын хороо нь 12 гишүүнтэй байх бөгөөд гишүүдийг 9 гишүүнтэй шийдвэрлэх бүрэлдэхүүн (hearing panel), 3 гишүүнтэй мөрдөн шалгах бүрэлдэхүүн (investigative panel) гэж хуваана. Бүрэлдэхүүн тус бүрт хуульч, шүүгч, иргэдийн төлөөллийг жигд оролцуулна. Бүрэлдэхүүний гишүүдийг нөгөө бүрэлдэхүүнд хуваарилж болох

²¹ Мөн тэнд.

²² Франц Улсын Шүүхийн тухай хуулийн 43 дугаар зүйл.

²³ Anja Seibert-Fohr, ed., *Judicial Independence in Transition*, Max Plank Institute, (Heidelberg: Springer, 2012), 290.

²⁴ Польш Улсын Шүүх байгууллагын тухай хуулийн 112 дугаар зүйл.

²⁵ European Network of Councils for the Judiciary, *Minimum Judicial Standards V: Disciplinary Proceedings and Liability of Judges*, 25.

²⁶ Cynthia Gray, *How Judicial Conduct Commissions Work*, 414.

боловч тухайн хэрэгт нэг бүрэлдэхүүнд орсон гишүүн нөгөө бүрэлдэхүүнд орохыг хориглодог.²⁷ Энэ загварыг баримталдаг мужуудад сахилгын хорооны тухайн гишүүн ямар ч шударга зан чанартай байсан мөрдөн шалгалтын материал, дүгнэлттэй урьдчилан танилцсан бол шийдвэрийн талаарх төсөөлөлтэй болдог бөгөөд ингэснээр шударга процессын зарчим алдагддаг гэж үздэг²⁸ учир мөрдөн шалгах, шийдвэрлэх гэсэн үндсэн хоёр чиг үүргийг төдийгүй мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих, хуралдаанд нотлох гэсэн чиг үүргийг бүхэлд нь салгасан.

1.3. Шүүгчийн сахилгын материаллаг хэм хэмжээ

Эрх зүйн салбарыг чиг үүргийн шинжээр нь материаллаг (material-хэрэглэгдэхүүн, эд юмс гэсэн франц үг) ба хууль зүйн процессын (processus-үйл хөдлөл гэсэн латин үг) эрх зүй гэж ангилан авч үздэг.²⁹ Нийгмийн харилцаанд дан ганц материаллаг эсхүл процессын хэм хэмжээ үйлчлэх боломжгүй бөгөөд тодорхой, ойлгомжтой, зөрчилгүй материаллаг болон процессын хэм хэмжээ нь цогц байдлаар хэрэгжиж байж зорилгодоо хүрдэг.

Шүүгчийн сахилгын процессын хувьд мөн ялгаагүй шүүгчийн ёс зүйн зөрчлийг тогтоосон материаллаг хэм хэмжээ байх зайлшгүй шаардлагатай. Шүүгчийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын суурь зарчмуудын 19-т “Сахилгын бүх ажиллагаа, шүүгчийг түдгэлзүүлэх, огцруулах зэрэг хариуцлага нь урьдчилан тогтоосон мэргэжлийн дүрмийн дагуу тогтоогдсон байна,” Шүүгчийн хараат бус байдлын талаарх Бангалорын зарчмыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тунхагийн 15.1-д “Шүүгчийн эрх зүйн байдлыг тогтоосон хууль тогтоомжоор шүүгчид сахилгын хэрэг үүсгэх, хариуцлага хүлээлгэх үндэслэл болсон мэргэжил (ёс зүй)-ийн дүрмийн талаар хуульд тухайлан заасан байна” гэж тус тус заасан байх бөгөөд ёс зүйн материаллаг хэм хэмжээ нь урьдчилан тогтоогдсон, нийтлэг, тодорхой байх гэсэн шалгуурыг хангасан байх ёстой нь харагдаж байна.

Шүүгчийн сахилгын процессын хүрээнд материаллаг хэм хэмжээ гэх ойлголтын хүрээнд ёс зүйн дүрэм (Code of Ethics), мэргэжлийн дүрэм (Code of Conduct) гэсэн ялгаатай нэршил бий. Эдгээрийн хороонд нарийн зааг ялгаа тогтоох боломжгүй бөгөөд олон талаар хоорондоо давхцах шинжтэй. Жишээ нь, Бельги, Хорват, Румын, Болгар Словени, Швед зэрэг оронд энэ хоёр дүрмийг зэрэг баталж мөрдүүлж байна.³⁰ Ёс зүйн хэм хэмжээ нь тухайн мэргэжлийн хүмүүсийн ерөнхийлөн баримталбал зохих идеаль шинжтэй хэм хэмжээ³¹ байх бөгөөд сахилгын процесс

²⁷ “Model Rules on Disciplinary Enforcement” (American Bar Association, 1994), Section 1, 1. http://www.americanbar.org/groups/professional_responsibility/model_rules_judicial_disciplinary_enforcement/rule3.html

²⁸ *Commentary on Rules for Judicial Disciplinary Enforcement.*, (American Bar Association, 1995) http://www.americanbar.org/groups/professional_responsibility/model_rules_judicial_disciplinary_enforcement.html

²⁹ Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, *Процессын эрх зүй: Онол, туршилага*, (УБ: Мэргэн Их Монгол, 2014), 23.

³⁰ European Network of Councils for the Judiciary, Minimum Judicial Standards V: Disciplinary Proceedings and Liability of Judges, 21.

³¹ Ийм нийтлэг зарчмыг баримталдаг Франц улсад нарийвчилсан дүрэм батлах тухай хэлэлцүүлэг ид өрнөж байна. Ерөнхий зарчмын дагуу асуудлыг шийдвэрлэх нь ямар зөрчлийг сахилгын хэрэг гэж үзэх нь эргэлзээтэй, сахилгын хэргийг шийдвэрлэх эрхтэй Шүүхийн дээд зөвлөл зөрчлийн шинж байдалд тохируулан өөрөө шалгадаг зэрэг нь шүүмжлэлд өртөж байсан бөгөөд Европын хүний эрхийн шүүхийн удаа дараагийн зөвлөмж, шийдвэрээр сахилгын процесст олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж иргэдийн оролцоог бий болгожээ.

Anja Seibert-Fohr, ed., *Judicial Independence in Transition*. 280.

эхлүүлэх үндэс болохгүй гэж үзэх нь ч бий.³² Харин мэргэжлийн дүрмийн хувьд зөрчсөн тохиолдолд шууд сахилгын хэрэг үүсгэн шалгах үндэслэл болдог байна.

Шүүгчийн сахилгын процессын материаллаг хэм хэмжээний хөндөгддөг мөн нэг асуудал нь ёс зүйн зөрчлийг мэргэжлийн алдаанаас хэрхэн зааглах тухай асуудал юм. Өөрөөр хэлбэл, шүүгчийн ёс зүйн зөрчлийн талаар ирүүлсэн гомдол нь давж заалдах журмаар хянагдаж засагдах ёстой хууль хэрэглээний болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа юу эсхүл шүүгчийн ёс зүйн зөрчил үү гэдгийг оновчтой, зөв тогтоох нь амаргүй. Мэргэжлийн алдаа болгоныг ёс зүйн зөрчилд тооцож эхэлбэл шүүгчийн хараат бус байдал алдагдана. Огт тооцохгүй бол шүүхэд итгэх иргэдийн итгэлд халтай. Жишээ нь Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудад шүүгч зөвхөн үйл баримтад хийсэн дүгнэлт болон хуульд тулгуурлан шүүн таслах чиг үүргээ үр нөлөөтэй, шударга, түргэн шуурхай хэрэгжүүлэх³³ үүрэгтэй гэж заажээ. Шүүгчийн ёс зүйн зөрчил болон мэргэжлийн алдааг хэрхэн зааглах талаар олон улсад тогтож байгаа үзэл баримтлал нь шүүгч 1) хэн ч ойлгохоор хуулийн заалтыг буруу тайлбарлан хэрэглэсэн, 2) өш хонзон, уур бухимдал, ялгаварлан гадуурхах зэрэг “зүй бус” сэдэлд хөтлөгдөн шийдвэр гаргасан, 3) хүний үндсэн эрх, процессын шаардлагыг зөрчсөн тохиолдолд ёс зүйн зөрчил гэж тооцдог.³⁴ Эндээс үзвэл хуулийг Үндсэн хуулийн болон эрх зүйн нийтлэг зарчмуудад нийцэхгүйгээр тайлбарлан хэрэглэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зүй бусаар, санаатайгаар удаашруулж саатуулах, Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчих нь өөрөө ёс зүйн зөрчилд тооцогдох бөгөөд олон нийтийн итгэлийг бууруулах сөрөг үр дагаварт хүргэдэг нь харагдаж байна.

1.4. Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх институт

Шүүгчийн сахилгын хэргийг шалган тогтоож, шийдвэрлэдэг институт нь шүүх, шүүхийн зөвлөл, бие даасан хороо, комисс зэрэг хагас шүүхийн шинжтэй байгууллагууд хэрэгжүүлдэг жишиг улс орнуудад байна. Эдгээр байгууллага нь хараат бус, зарчимч, шударга, төвийг сахих шаардлага тавигддаг шүүгчдийн сахилга, ёс зүйг сахиулдаг чиг үүрэгтэй тул хараат бус, бие даасан байдал, чиг үүргээ хэрэгжүүлэх баталгаа, үйл ажиллагааны журам зэрэг нь шүүгчийнхээс дутахааргүй байх ёстой.

Сахилгын хорооны бүрэлдэхүүн: Олон улсын Барын холбооны 1982 оны Шүүхийн хараат бус байдлын талаарх минимум стандартад “Шүүгчийн ёс зүй сахилгын зөрчлийн талаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нь хэрэг үүсгэх, шалгах чиглэлээр оролцож болох боловч түүнийг хянан шийдвэрлэхэд оролцохгүй. Шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах, албан тушаалаас огцруулах зэрэг чиг үүргийг гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус, бие даасан институт шийдвэрлэнэ”³⁵, Олон улсын шүүгчдийн холбооноос гаргасан Шүүгчийн түгээмэл дүрэм (The Universal Charter of the Judge) –ийн 11 дүгээр зүйлд “Сахилгын хэргийг шалгах, хянан шийдвэрлэх чиг үүргийг хараат бус, шүүгчдийн үндсэн төлөөлөлтэй субъект хэрэгжүүлнэ”, Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тунхаглалын 15.4-д “Сахилгын хэргийг хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус, ажиллаж байгаа болон тэтгэвэрт гарсан шүүгчид, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэлд ажилладаггүй бусад этгээдийн төлөөлөл бүхий бие даасан хороо, зөвлөл зэрэг хагас шүүхийн байгууллага (quasi-judicial) шийдвэрлэнэ” зэргээр сахилгын хэргийг хянан шийдвэрлэдэг субъектэд тавьдаг нийтлэг

³² Мөн тэнд.

³³ The Bangalore Principles on Judicial Conduct, (Judicial Group on Strengthening Judicial Integrity, 2002), 1.1, 6.5

³⁴ Cynthia Gray, “The Line Between Legal Error and Judicial Misconduct: Balancing Judicial Independence and Accountability”, *Hofstra Law Review* Vol. 32:1245 (2004): 1245-1280

³⁵ Minimum Standards on Judicial Independence, (International Bar Association, 1982), 3.a, <http://www.ibanet.org>.

жишгийг тодорхойлжээ. Мөн эдгээр институтын бүрэлдэхүүнд иргэдийн төлөөллийг оруулах нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүгчийн сахилгыг хэрхэн сахиулж байгаад иргэдийн хяналтыг тавих ач холбогдолтой³⁶ тул бүрэлдэхүүнд шүүгчдийн зэрэгцээ иргэд, олон нийтийн бодит төлөөллийг оруулах шаардлага тавигддаг.

Жишээ нь Франц улсад мөрдөн шалгах, шийдвэрлэх чиг үүрэг бүхий Шүүхийн дээд зөвлөл (Conseil Superieur de la Magistrature-CSM)-ийн³⁷ Шүүхийн хороог Дээд шүүхийн Ерөнхий шүүгч тэргүүлэх бөгөөд таван шүүгч, нэг прокурор, Төрийн зөвлөлөөс томилогдсон нэг төлөөлөгч, нэг хуульч, зургаан иргэн, нийт 13 гишүүнтэй байна.³⁸ Польшид мөрдөн шалгах үүргийг сахилгын төлөөлөгч, шийдвэрлэх үүргийг сахилгын шүүх хэрэгжүүлдэг. Сахилгын төлөөлөгчийг Шүүхийн дээд зөвлөлөөс томилох бөгөөд сахилгын хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй сахилгын шүүх хянан шийдвэрлэдэг. АНУ-д мөрдөн шалгах болон шийдвэрлэх үүргийг Шүүхийн сахилгын хороо хэрэгжүүлэх бөгөөд хороо нь шүүгч, хуульч, иргэд гэсэн гурван талын жигд төлөөллөөс бүрддэг.³⁹ Өөрөөр хэлбэл, шүүгч, хуульч, иргэдийн төлөөллийн аль алиных нь тэнцвэрийг харьцангуй хангасан байгаагийн зэрэгцээ төрийн эрх мэдлийн бусад салбарын төлөөллийг оруулаагүй нь хорооны бие даасан байдлыг хадгалах зорилготой харьцангуй олон улсын жишиг шаардлагад нийцсэн хувилбар юм.

Томилгоо, бүрэн эрхийн хугацааны хувьд улс төрийн болон бусад эрх мэдлийн нөлөөнөөс ангид байх, хорооны өөрийнх нь бие даасан байдлыг хадгалж хамгаалах шаардлага тавигддаг. Францын Шүүхийн дээд зөвлөлийг өмнө нь Ерөнхийлөгч томилдог байсан нь тухайн байгууллага улс төрийн хувьд ихээхэн хамааралтай, институтын бие даасан байдлыг алдагдуулж байна гэсэн шүүмжлэлд өртсөн⁴⁰ тул шүүгч, прокурор зэрэг 12 гишүүнийг шүүхийн шат тус бүрээс шууд сонгодог болсон. Шүүгч бус гишүүдийг Ерөнхийлөгч, Сенатын танхим, Төрийн зөвлөлийн Ерөнхий ассемблейгаас тус бүр хоёрыг томилдог.⁴¹ Харин Польш улсын хувьд сахилгын хэргийг мөрдөн шалгах төлөөлөгчийг Шүүхийн үндэсний зөвлөлөөс давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэр дэвшүүлсэн шүүгчдийн дундаас дөрвөн жилийн бүрэн эрхийн хугацаагаар томилно.⁴² АНУ-ын хувьд гишүүдийн томилгоог аль нэг субъектэд бүрэн харьяалуулахгүй байх хандлагатай. Тухайлбал, Хуульчдын холбооноос гаргасан Шүүгчдийн сахилгыг сахиулах загвар дүрэмд Сахилгын хорооны 4 шүүгч гишүүнийг давж заалдах, эсхүл хяналтын шатны шүүхээс, 4 хуульч гишүүнийг Хуульчдын холбооноос, 4 иргэдийн төлөөлөл гишүүнийг мужийн захирагчаас томилохоор заасан.⁴³

Энэ хэсэгт шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэдэг институтийн онцлог, чиг үүрэг, бүрэлдэхүүн, тэдгээрт тавигдах шаардлага, томилгоо, бие даасан хараат бус байдлын талаар авч үзлээ. Үүний дагуу институтэд тавигдах олон улсын нийтлэг шаардлагыг (1) Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус, (2) Бие даасан статустай, (3) Шүүгч болон олон нийтийн “зохих” төлөөлөлтэй байх гэж тодорхойлов.

³⁶ Мөн тэнд., 409.

³⁷ Бүгд Найрамдах Франц Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 66.6 дахь хэсэг “Шүүхийн дээд зөвлөлийн хэсэг нь шүүгчид холбогдсон сахилгын хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн үүргийг гүйцэтгэнэ.”

³⁸ Мөн тэнд., 2 дахь хэсэг.

³⁹ Канзас мужийн дээд шүүхийн тогтоосон дүрэм, (1995), 602b.

⁴⁰ Anja Seibert-Fohr, ed., *Judicial Independence in Transition*, 279.

⁴¹ Мөн тэнд., 278.

⁴² Польш улсын Шүүх байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйл.

⁴³ Model Rules for Judicial Disciplinary Enforcement, Section 1, Rule No.2. (American Bar Association 1994).

1.5. Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

А. Сахилгын хэрэг үүсгэх

Гомдол хүлээн авах, урьдчилан шалгах ажиллагаа: Гомдол мэдээлэл хүлээн авах нь зарим улс оронд шүүгчид холбогдуулан сахилгын хэрэг үүсгэх урьдчилсан шат болдог бол тодорхой субъект санаачилгаараа зөрчлийг шалгадаг улс оронд сахилгын хэрэг урьдчилан шалгах шат байхгүй. Олон улсад зөвлөмж бүхий баримт бичгүүдэд гомдлын дагуу хэрэг үүсгэх эсхүл гомдлыг хэрэгсэхгүй болгох талаар шийдвэрлэдэг албан ёсны шүүлтүүр (filter)-ийг бүрдүүлэх шаардлагатай гэж үздэг.⁴⁴ Энэ нь нэг талаар шүүгчийг хэт буруутгах, “хашраах” гэсэн аливаа хувийн сэдэлттэй, эсхүл шүүхийн шийдвэрт сэтгэл ханамжгүй үлдсэн талын шүүхийн дараагийн шатанд шийдвэрийг өөрчлүүлэх гэсэн зорилготой гомдолд сахилгын институт дарагдахаас сэргийлнэ.⁴⁵ Жишээ нь, Европын шүүхийн зөвлөлүүдийн сүлжээнээс гаргасан Шүүгчийн сахилгын процессын минимум стандарт баримт бичигт мөн шүүгчийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдлыг хүлээн авах, нягтлан шалгах тусдаа механизм, субъект, ялангуяа Хууль зүйн яамнаас хараат бус субъект байх ёстойг тэмдэглэсэн.⁴⁶ Гомдол шалгах ажиллагааны явцад гомдолд холбогдсон шүүгчид мэдэгдэх шаардлагагүй бөгөөд энэ нь хэрэгт зайлшгүй шаардлагатай нотлох баримт устаж үгүй болох, үндэслэлгүй (vexatious) буюу шүүхийн процесс, шийдвэрт сэтгэл ханамжгүй үлдсэн, тийм магадлалтай талын гаргасан шаардлагагүй гомдолд шүүгч болон ёс зүйн хороо дарагдахаас сэргийлнэ.⁴⁷

Сахилгын хэрэг үүсгэх тухайд Шүүгчийн ёс зүйн талаарх Банглорын зарчмыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тунхаглал⁴⁸-ын 15.3-т “...цугларсан баримтанд тулгуурлаж сахилгын хэрэг үүсгэн шалгах хангалттай нөхцөл байдал тогтоогдсон эсэхийг шийдвэрлэнэ”⁴⁹ гэжээ. Польшид Хууль зүйн сайд, давж заалдах болон засаг захиргааны нэгж дундын шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн үндэсний зөвлөлийн хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар урьдчилан цугларсан баримт, мэдээлэлд тулгуурлан Сахилгын төлөөлөгч (Disciplinary Commissioner) сахилгын хэрэг үүсгэн шалгадаг⁵⁰ бол АНУ-ын хувьд Сахилгын мэргэжилтэн (Disciplinary Counsel) гомдол болон өөрийн санаачилгаар урьдчилсан ажиллагаа⁵¹ явуулж, хэрэг үүсгэн шалгах үндэслэлтэй гэж үзвэл Мөрдөн шалгах хороонд танилцуулж, мөрдөн шалгах хороо дүгнэлтийг нягтлан шалгаад сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэдэг байна.⁵²

Б. Сахилгын хэргийг мөрдөн шалгах ажиллагаа

Мөрдөн шалгах эрх хэмжээ: Сахилгын хэргийг мөрдөн шалгах ажиллагаа нь хэрэгт хамааралтай нотлох баримт цуглуулах, гомдолд холбогдсон шүүгчид албан ёсоор мэдэгдэх,

⁴⁴ Ийм механизм нь НҮБ-ын Шүүгчийн хараат бус байдлын талаарх суурь зарчмуудын 17-20 дугаар зарчим, Олон улсын шүүгчдийн холбооноос гаргасан Шүүгчдийн түгээмэл дүрмийн 8 болон 11 дэх хэсэгт заасан “сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шударга, цаг алдахгүй, шуурхай байх зарчим”-ыг хангахад ач холбогдолтой юм.

⁴⁵ European Network of Councils for the Judiciary, Minimum Judicial Standards V: Disciplinary Proceedings and Liability of Judges, 27.

⁴⁶ Мөн тэнд., 28.

⁴⁷ European Network of Councils for the Judiciary, Minimum Judicial Standards V: Disciplinary Proceedings and Liability of Judges, 27.

⁴⁸ Measures for the Effective Implementation of the Bangalore Principles of Judicial Conduct (Lusaka, Zambia 2010), in Compilation of International Standards on Judicial Reform and Judicial Independence.

⁴⁹ Мөн тэнд., 15 дугаар зүйлийн 15.3.

⁵⁰ Польш улсын Шүүхийн байгууллагын тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 114.2.

⁵¹ Урьдчилсан ажиллагаа гэдэгт тайлбар мэдүүлэг авах, нотлох баримтыг шинжлэн судлах зэрэг болно.

⁵² “Model Rules on Disciplinary Enforcement” (American Bar Association, 1994), Rule 17.1.

гэрчээс мэдүүлэг авах, шинжээчээр дүгнэлт гаргуулах зэрэг цогц ажиллагаа байна. Энэхүү цогц ажиллагааг гүйцэтгэхийн тулд мөрдөн шалгах эрх бүхий субъект нь процессын тодорхой арга хэрэгсэл, эрх хэмжээтэй байх ёстой. Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тунхаглалын 2.2-т “...Хороо зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаагаа хэвийн явуулахын тулд хуулиар тодорхой албадлагын эрх хэмжээгээр хангагдсан байна” гэж заасан. Европын шүүхийн зөвлөлүүдийн сүлжээнээс гаргасан баримт бичигт “шүүгчийн ёс зүйн зөрчлийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй субъект нь бичгэн болон аман нотлох баримт цуглуулж хэрэгт авах зэрэг боломжтой байх ёстой”⁵³ гэжээ. Шүүгчийн ёс зүйн маргаан нь маргааны талуудад нотлох үүрэг хүлээлгэдэг хувийн эрх зүйн маргаан биш, харин нийтийн ашиг сонирхол хөндөгддөг нийтийн эрх зүйн маргаан⁵⁴ учир сахилгын хэргийг нотлох чиг үүрэг нь талуудад биш тусгайлсан субъектэд байдаг нь энэ процесст мөрдөн шалгах эрх хэмжээ шаардлагатайг илтгэн харуулдаг. Жишээ нь Францын хувьд мөрдөн шалгах ажиллагаа гүйцэтгэж байгаа Шүүхийн зөвлөлийн гишүүн шүүгчээс хариу тайлбар авах, гэрч, гомдол гаргагчаас хууль сануулж тайлбар, мэдүүлэг авах эрүүгийн процессын мөрдөн шалгах бусад боломжит бүхий л арга хэмжээг авч болохыг хуульчилж тогтоосон.⁵⁵ Польш улсын хувьд Шүүхийн тухай хуульдаа мөрдөн шалгах тодорхой ажиллагааг хуульчлаагүй боловч тус хуулиар зохицуулаагүй мөрдөн шалгах асуудлыг Эрүүгийн процессын хуулиар зохицуулахаар заасан,⁵⁶ АНУ-д гэрч, шинжээчид хууль сануулах, мөрдөн шалгах ажиллагааг бүрэн эхлүүлсэн тохиолдолд шүүгч, гэрчийг байцаах, мөрдөн шалгах ажиллагаанд зориулж эд мөрийн баримтыг хураан авах, хэрэгт хавсаргах зэрэг эрх хэмжээтэй.⁵⁷ Судалсан улсуудад сахилгын хэргийг бүх талаас нь бүрэн гүйцэд шалгахын тулд мөрдөн шалгах эрх хэмжээг тодорхой субъектэд олгосон байна.

Мөрдөн шалгах эрх хэмжээний хүрээнд хөндөгддөг бас нэг чухал асуудал нь ёс зүйн зөрчлийг шалгах ажиллагаа гомдлоор хязгаарлагдах уу гэсэн асуудал юм. Сахилгын процессын өөрийнх нь онцлог, мөрдөн шалгах эрх бүхий субъект санаачилгаараа хэрэг үүсгэн шалгах эрхтэй байдаг зэргээс үзвэл шалгах хүрээ нь зөвхөн гомдлоор хязгаарлагддаггүй. Тухайлбал, Польшийн Шүүх байгууллагын тухай хуулийн 117 дугаар зүйлд “Сахилгын хэргийг шийдэх явцад өөр ёс зүйн зөрчил илэрвэл Сахилгын шүүх сахилгын төлөөлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр тухайн хэргийг шийдвэрлэх бөгөөд шинээр илэрсэн зөрчилд тусад нь сахилгын хэрэг үүсгэн шалгана” гэж заасан. АНУ-ын хувьд мөн адил ёс зүйн зөрчил байна гэж үзвэл түүнийг шалгах эрх хэмжээ Мөрдөн шалгах хороонд хадгалагддаг. Эндээс дүгнэвэл гомдол болон сахилгын хэргийг шалгах явцад өөр ёс зүйн зөрчил илэрвэл түүнд холбогдуулан санаачлагаараа шалгаж тогтоох, шийдвэрлэх эрх аль ч улсад байна. Хэрэв зөвхөн гомдлын хүрээгээр шалгана гэж үзвэл шүүгчийн гаргасан ёс зүйн ноцтой зөрчил гомдолд дурдагдаагүй гэсэн үндэслэлээр шалгагдахгүй өнгөрөх, улмаар шүүхэд итгэх хуульч, олон нийтийн итгэлд сөргөөр нөлөөлөх үр дагавартай байх нь дамжиггүй.

Чиг үүрэг, чиг үүргийн хуваарилалтын хувьд: Сахилгын процесс дахь шалгах, нотлох, хяналт тавих, шийдвэрлэх чиг үүргийг хуваарилах нь сахилгын хэргийг хянан шийдвэрлэх

⁵³ European Network of Councils for the Judiciary, Minimum Judicial Standards V: Disciplinary Proceedings and Liability of Judges, 28.

⁵⁴ О.Мөнхсайхан, “Монгол Улс дахь шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам”, *Шүүх эрх мэдэл*, дугаар 1 (2016): 37 дахь талд энэ тухай тайлбарласан.

⁵⁵ Франц улсын Шүүх байгууллагын тухай хуулийн 52 дугаар зүйл.

⁵⁶ Польш улсын Шүүх байгууллагын тухай хуулийн 128 дугаар зүйл.

⁵⁷ Model Rules for Judicial Disciplinary Enforcement, (ABA, 1994). Rule 14.1, 14.2.

ажиллагааны шударга, төвийг сахих зарчмыг хангахад чухал ач холбогдолтой гэж үздэг.⁵⁸ Тухайлбал, Европын шүүхийн зөвлөлүүдийн сүлжээнээс гаргасан Шүүгчийн сахилгын процесс ба шүүгчийн хариуцлагын минимум стандарт судалгаанд шүүгчийн сахилгын хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх гэсэн хоёр чиг үүргийг салгаж, өөр өөр субъектэд хүлээлгэх ёстойг тэмдэглэжээ.⁵⁹ Польшид эдгээр чиг үүргийг Сахилгын төлөөлөгч, Сахилгын шүүх гэсэн субъектэд, АНУ-д шалгах, нотлох үүргийг сахилгын мэргэжилтэнд, мөрдөн шалгах эрх олгох, хяналт тавих үүргийг Мөрдөн шалгах хороонд, шийдвэрлэх чиг үүргийг хянан шийдвэрлэх хороонд харьяалуулж чиг үүргийн хуваарилалтыг хийжээ.

В. Сахилгын хэргийг шийдвэрлэх, шийдвэрт давж заалдах

Олон улсын шүүгчдийн холбооны Шүүгчийн түгээмэл дүрмийн 11 дүгээр зүйлд “Шүүгчийн ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх ажиллагаа нь шүүгчийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлж болохгүй бөгөөд төвч, хэрэгт хамааралтай байдлыг бүрэн тогтоох зарчмын дагуу явагдана” хэмээн заасан.⁶⁰ АНУ-ын хувьд Хуульчдын холбооноос гаргасан загвар дүрэмд шүүгчид холбогдох дүгнэлтэд шүүгч хариу тайлбар өгсөн, эсхүл ийнхүү хариу тайлбар өгөх хугацаа дууссан бол Сахилгын хэргийг шийдвэрлэх хороо хуралдааны товыг зарлаж, оролцогчдод энэ тухай мэдэгддэг. Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд өмнө нь тухайн зөрчлийг шалгасан, шалгахаар чиглэл өгсөн субъект ордоггүй. Сахилгын хэргийг шийдвэрлэх хуралдаанд сахилгын мэргэжилтэн өөрийн шалгасан хэргийн дүгнэлт, хэрэгт авагдсан нотлох баримтыг танилцуулж, нотлох байр суурьтай⁶¹ оролцдог. Хорооны хуралдаанаас сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох, сахилгын шийтгэл оногдуулах гэсэн шийдвэрийн аль нэгийг гаргана. Сахилгын шийтгэл оногдуулах шийдвэр гаргасан бол огцруулахаас бусад шийтгэлийг хороо шууд оногдуулах бол огцруулах шийтгэлийг томилох эрх бүхий субъектэд зөвлөмж болгож гаргана.⁶² Сахилгын хэргийг шийдвэрлэх ажиллагаа нь тухайн холбогдсон шүүгчийн процессын эрхийг хангасан, тусгайлан зааснаас бусад тохиолдолд нээлттэй, хараат бус байх, шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэлтэй байх ёстой.

Сахилгын хэргийг шийдвэрлэсний дараа шүүгч эсхүл сахилгын хороонд давж заалдах эрх байх ёстой гэсэн хандлага олон улсад байна. Тухайлбал, Шүүгчийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын суурь зарчмуудын 20-д “Шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах болон албан тушаалаас нь чөлөөлөх ажиллагаа хараат бус хяналт (орч. Review)-д байна,” гэсэн бол Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тунхаглалын 15.6-д “Ёс зүйн талаар гаргасан шийдвэрийг шүүхэд давж заалдах процесс байх ёстой.” зэргээр тусгасан бөгөөд давж заалдах шатны журмаар шүүх, тусдаа хороо, зөвлөл зэрэг хагас шүүхийн шинжтэй байгууллагын аль нь шийдвэрлэх тухай тодорхой тусгаагүй, нэгдсэн жишиг байхгүй байна.

Европын орнуудын хувьд давж заалдах эрх нийтлэгээр байх боловч харилцан адилгүй байна. Жишээ нь сахилгын хэргийг дээд шүүх нь эцэслэн шийдвэрлэдэг улс оронд (Жишээ нь Чех,

⁵⁸ “Сахилгын хорооны тухайн гишүүн ямар ч шударга зан чанартай байсан мөрдөн шалгалтын материал, дүгнэлттэй урьдчилан танилцсан бол шийдвэрийн талаарх төсөөлөлтэй болдог бөгөөд ингэснээр шударга процессын зарчим алдагддаг.” Commentary on Rules for Judicial Disciplinary Enforcement.

⁵⁹ European Network of Councils for the Judiciary, Minimum Judicial Standards V: Disciplinary Proceedings and Liability of Judges, 28.

⁶⁰ European Network of Councils for the Judiciary, *Minimum Judicial Standards V: Disciplinary Proceedings and Liability of Judges*, 28.

⁶¹ Model Rules for Judicial Disciplinary Enforcement, (ABA, 1994) Rule No. 24, 4(2).

⁶² Мөн тэнд., 24 дүгээр зүйлийн 24.4.

Нидерланд) ийм давж заалдах эрхийн асуудал хөндөгдөхгүй. Бельги, Унгар, Словак, Словени зэрэг оронд давж заалдах шатны сахилгын шүүх, түүний бүрэлдэхүүн зэрэг субъект, Албани, Бельги, Франц, Болгар, Итали, Серби, Испани, Туркэд захиргааны хэргийн шүүх, Төрийн зөвлөл, Австри, Хорват, Дани, Литва, Польш, Португаль зэрэг оронд үндсэн хуулийн шүүх эсхүл дээд шүүх нь сахилгын хэргийг давж заалдах шатны журмаар шийдвэрлэж байна.⁶³ АНУ-ын хувьд сахилгын хэргийг шийдвэрлэсэн шийдвэрт давж заалдах тухай зохицуулалт муж тус бүрээс хамаарч харилцан адилгүй байна. Зарим мужид сануулах зэрэг шийтгэлийг ёс зүйн хороо өөрөө, огцруулах, бүрэн эрхийг түдгэлзүүлэх зэрэг шийтгэлийг зөвхөн дээд шүүх оногдуулдаг. Улс орнуудын нийтлэг жишгээр давж заалдах эрх зайлшгүй бөгөөд шүүгчийн сахилгын хэрэгт зөвхөн нэг удаа давж заалдах боломжтой байдаг нь харагдаж байна.

Энэ хэсэгт шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрийн тусгайлан авч үзсэн бөгөөд шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нийтлэг шалгуурыг (1) Гомдлыг урьдчилан шалгах тодорхой ажиллагаатай байх, (2) мөрдөн шалгах эрх хэмжээтэй байх, (3) өөрийн санаачилгаар хэрэг үүсгэх, шалгах эрх хэмжээтэй байх буюу гомдлын хүрээгээр хязгаарлагдахгүй байх, (4) үйл ажиллагаа, эрх зүйн байдал нь хуулиар тодорхойлогдсон байх, (5) шийдвэр нь давж заалдах шатны журмаар хянагдах боломжтой байх, (6) шалгах, шийдвэрлэх чиг үүргийг хуваарилсан байх гэсэн шаардлагыг тодорхойлов.

2. МОНГОЛ УЛС ДАХЬ ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ПРОЦЕССЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Энэ хэсэгт Монгол Улс дахь шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх өнөөгийн процесст тулгамдаж байгаа асуудлыг олон улсын нийтлэг жишиг, зөвлөмж, судлаачдын байр суурь, судалгаа, хуулийн хэрэгжилтийн асуудлууд дээр тулгуурлан тодорхойлж, шийдвэрлэх арга зам, хувилбарыг дэвшүүлнэ.

2.1. Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх харьяалал

Шүүгч ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд түүнийг харьяалан шалгаж, хянан шийдвэрлэхтэй холбоотой дараах хоёр асуудал бий: Нэгд, шүүгчийн ёс зүйн зөрчлийг тодорхойлсон материаллаг хэм хэмжээний давхардлаас болж, түүнийг хянан шийдвэрлэх харьяалал давхардсан. Хоёрт, шүүгчийн гаргасан мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчил хоорондын зааг ялгааг оновчтой тогтоогоогүйн улмаас ШЁЗХ-ны харьяалан шалгаж шийдвэрлэх зөрчлийн хүрээ хумигдсан.

Нэг дэх асуудал нь шүүгчийн ёс зүйн материаллаг хэм хэмжээний давхардлаас эхлэлтэй. Монголын Хуульчдын холбоо (МХХ)-ны Шүүгчдийн хорооноос баталсан ШЁЗД нь шүүгчийн хувьд баримтлах зарчим, даган биелүүлэх хэм хэмжээг тодорхойлсон.⁶⁴ Үүнтэй зэрэгцэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2-т заасны дагуу Хуульчдын их хурлаас Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийг баталсан. Эдгээр дүрмийн аль аль нь хуульчийн баримтлах хэм хэмжээг нарийвчлан тодорхойлсон бөгөөд үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ёс зүйн хэмжээ, хариуцлагыг тусгасан ижил зорилготой бөгөөд цөөнгүй хэсэг нь давхцдаг.⁶⁵ Ингэснээр шүүгч нэг талаас ШЁЗ дүрмээ баримтална, нөгөө талаас хуульчийнхаа

⁶³ European Network of Councils for the Judiciary, Minimum Judicial Standards V: Disciplinary Proceedings and Liability of Judges, 39.

⁶⁴ 2014 оны “Шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийн 1 дүгээр зүйлийн 1.1.

⁶⁵ ШЁЗД болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн шүүгч гэсэн ангид: хүндэтгэлтэй хандах, нэр хүндийг хамгаалах тухай, шударга байж, төвийг сахих тухай, тэгш хандах, хууль

хувиар Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийг баримтлахаар ойлгогдож байна. Материаллаг хэм хэмжээний энэ давхардал нь процессын ажиллагаанд ямар субъект шүүгчийн гаргасан ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх вэ гэдэгт мөн давхардал үүсгэсэн.⁶⁶ Өөрөөр хэлбэл, шүүгчид аль аль дүрэм нь үйлчилнэ, зөрчил гаргавал МХХ-ны Мэргэжлийн хариуцлагын хороо, ШЁЗХ-ны аль аль нь харьяалан шийдвэрлэх боломжтой.

Шийдвэрлэх арга замын тухайд шүүгчийн ёс зүйн зөрчлийг шалгах, шийдвэрлэх харьяаллыг ШЁЗХ-нд шилжүүлэх нь оновчтой гэж үзэж байна. Учир нь шүүгчийн ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх бүрэлдэхүүнтэй холбоотой. ШЁЗХ-ны бүрэлдэхүүнд прокурор, өмгөөлөгч зэрэг шүүхэд аль нэг тал болон мэтгэлцдэг субъект орохыг хориглодог бол МХХ-ны Мэргэжлийн хариуцлагын хорооны нийт 30 гишүүний 6 нь буюу 20 хувь нь өмгөөлөгч, мөн 20 хувь нь прокурор байдаг.⁶⁷ ШЁЗХ-нд шүүгч орохыг хориглодог бол МХХ-ны нийт 30 гишүүний 18 нь буюу талаас дээш хувь нь шүүгч байдаг.⁶⁸ Нэг талаас шүүгчийн ёс зүйн зөрчлийг шалгах, шийдвэрлэхэд шүүхийн өмнө мэтгэлцдэг талуудыг оролцуулахыг хязгаарлаж, шүүгчийн хараат бус байдал хөндөгдөхөөс сэргийлэх, нөгөө талаас шүүгчид шүүгчийнхээ ёс зүйн асуудлыг шийдвэрлэхээс татгалзах хандлагыг чиг баримжаа болговол ШЁЗХ-нд энэ чиг үүргийг шилжүүлэх нь оновчтой байж болох юм.⁶⁹

Хоёр дахь асуудал нь мөн шүүгчийн ёс зүйн материаллаг хэм хэмжээтэй холбоотой. ШЁЗД-ээр шүүгчийн албаны үйл ажиллагаа болон хувийн амьдралдаа баримтлах зарчим, даган биелүүлэх хэм хэмжээг тодорхойлж, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхийг зорилго болгосон⁷⁰ боловч тус дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2-т “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, үр чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж зааснаар шүүгчийн албаны үйл ажиллагаанд ёс зүйн хэм хэмжээ үйлчлэх эсэхэд эргэлзээ үүсгэсэн. Жишээ нь шүүгч хуулийг илтэд буруугаар тайлбарлаж, хүний эрхийг ноцтой зөрчсөн шийдвэр гаргасан тохиолдолд хариуцлага хүлээхгүй байх боломжтой.⁷¹

зүйн үйлчилгээний тухай, татгалзан гаргах, шүүгч бусдын талаар тодорхойлохгүй байх, бусдаас бэлэн мөнгө, тусламж авахгүй байх, хэргийн оролцогчтой харилцах, хэргийн талаар олон нийтэд мэдээлэх, бусад үйл ажиллагаа эрхлэх, ашиг сонирхлын зөрчил зэрэг арав гаруй асуудлыг давхардуулан зохицуулсан. Энэхүү асуудлын хүрээнд судлаач Д.Булганы “Шүүхийн ёс зүйн хороо болон Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргааныг харьяаллыг зааглах асуудал” өгүүлэлд авч хувь судлаачын санал, дүгнэлттэй санал нэгтэй байгаа тул энэ талаар цааш дэлгэрэнгүй авч үзсэнгүй.

⁶⁶ 2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 “Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзсэн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Ёс зүйн хороонд хандана.” гэж Шүүгчийн ёс зүйн дүрэм зөрчсөн тохиолдолд гомдол гаргах харьяаллыг, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 “Хуульч энэ хууль, Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхгүйг Мэргэжлийн хариуцлагын хороонд мэдэгдэх үүрэгтэй” гэж хуульчийн мэргэжлийн дүрэмд заасан зөрчил гаргасан тохиолдолд мэдээлэх харьяаллыг заасан.

⁶⁷ 2012 оны Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.3.

⁶⁸ Мөн тэнд.

⁶⁹ Гэхдээ ийнхүү ШЁЗХ-нд шүүгчийн ёс зүйн асуудлыг бүрэн харьяалуулахдаа Шүүгчийн ёс зүйн дүрмийг боловсронгуй болгосны үндсэн дээр шийдвэрлэх нь зүйтэй. Учир нь өнөөгийн ШЁЗД нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрэмтэй харьцуулбал 1) шүүгчийн ёс зүйн олон улсын стандарт, зарчмууд бүрэн тусаагүй, 2) шүүгчийн ёс зүйн олон улсын зарчим, стандартад нийцэхгүй зохицуулалтууд цөөнгүй бий.

О.Мөнхсайхан нар, *“Монгол Улс дахь шүүхийн захиргааны загвар: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам”*, 114.

⁷⁰ 2014 оны “Шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийн 1 дүгээр зүйлийн 1.1.

⁷¹ ШЁЗХ нь энэ төрлийн хэд хэдэн зөрчлийг хянан шийдвэрлэж, шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан. 2015 онд ШЁЗХ-ны нийт 14 сахилгын хэрэг ЗХДЗШШ, УДШ-ээр хянан хэлэлцэгдэж, 13 шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хамаарах алдааг ёс зүйн зөрчилд тооцсон гэсэн үндэслэлээр хүчингүй болжээ.

Нэгэнт ёс зүйн зөрчилд тооцогдохгүй гэсэн учир ШЁЗХ зөрчлийг шалган тогтоож, хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөл байдлыг бий болгосон.

Гэхдээ ШЁЗХ-ны хувьд шүүгчийн ёс зүйн онолд байдаг утгаар дараах хоёр нөхцөл хангагдсанаас бусад тохиолдолд шүүгчийн хууль хэрэглэсэн алдаанд хариуцлага хүлээлгэхгүй байх жишиг тогтоосон: 1) Үндсэн хуулиар илэрхий хамгаалагдсан үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн; 2) хэн ч маргахгүй хуулийн тодорхой заалтыг зөрчсөн, ялангуяа удаа дараа зөрчсөн.⁷² Жишээ нь ШЁЗХ-ны 2015 оны 9 сарын 17-ны өдрийн 55 дугаар магадлалд дээрх хоёр жишгийг хоёуланг баримталжээ:

Шүүгч Ч.Ц нь ИХШХШТХ-ийн 65.1.10-т “хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд маргаж байгаа шаардлага буюу маргаантай үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй бол шүүгч захирамж гарган нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана” гэж заасан байтал тухайн хуулийн этгээд татан буугдаагүй байхад уг хэргийг гурван удаа давтан хэргийг хэрэгсэхгүй болгосон. Тухайн хуулийн этгээдийг татан буугдаагүй гэдгийг захирамж гаргах бүрдээ мэдэж байсан төдийгүй хүлээн зөвшөөрсөн. Ёс зүйн хорооны хуралдаанаар шүүгч Ч.Ц-д сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоол гаргасан бөгөөд Хорооны нийт гишүүдийн хуралдаанаас уг тогтоолыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэсэн.⁷³

Магадлалын үндэслэх хэсэгт шүүгч “Ч.Ц нь 1) Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3-д заасан “шүүгч хууль дээдлэх зарчим”, 3.3 дугаар зүйлд заасан “шүүгч хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд хэрэгжүүлэх” үүргийг зөрчиж процессын хуулийн тов тодорхой заалтыг удаа дараа зөрчсөн төдийгүй нэхэмжлэгч талын Үндсэн хуульд заасан шударгаар шүүлгэх эрхийг зөрчсөн”⁷⁴ гэж үндэслэлээ тайлбарласан. Энэ магадлалыг ЗХДШШ-ээс хянан шийдвэрлэсэн⁷⁵ бөгөөд шүүх “Шүүхийн ёс зүйн хорооны магадлалд шүүгчийн ёс зүйн дүрмийн тодорхой заалтуудыг зөрчсөн байна гэсэн дүгнэлтийг хийсэн атлаа гомдлыг дахин шалгуулахаар буцаан шийдвэрлэсэн нь ойлгомжгүй, зөрчилтэй болжээ” гэсэн дүгнэлтийг хийж магадлалыг хүчингүй болгон дахин хэлэлцүүлэхээр буцаасан бол УДШ-ийн Захиргааны хэргийн хяналтын шатны шүүх хуралдаанаар магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн⁷⁶ бөгөөд үндэслэлээ “шүүгчийн хууль хэрэглэх, мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой асуудалд дүгнэлт өгч, Шүүгчийн ёс зүйн дүрмийн холбогдох заалтуудыг буруу тайлбарлан хэрэглэсэн байна” гэж буюу ШЁЗД-ийн 1.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хатуу баримталж, шүүгчийн мэргэжлийн ямар ч алдаанд ноцтой эсэхээс нь үл хамаарч хариуцлага хүлээлгэхгүй гэж шийдвэрлэсэн.

Хэдийгээр энэ хэрэг нь өнөөгийн ШЁЗД-ийн явцуу хүрээнд шийдвэрлэгдсэн боловч шүүгчийн сахилга, ёс зүйн олон улсын стандарт, жишгийн үүднээс авч үзвэл ноцтой үр дагавартай. Шүүгчийн мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчлийг нарийн зааглахад төвөгтэй боловч тодорхой баримталдаг шалгуур бий. Шүүгч санаатайгаар мэргэжлийн алдаа (өш хонзон, шунахай, уурлаж бухимдах зэрэг сэдэлттэй байж болно) гаргасан, шууд тодорхой заасан хуулийн заалт болон процесс зөрчсөн, хүний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн зэрэг тохиолдолд шүүгчид

⁷² О.Мөнхсайхан нар, *Монгол Улс дахь шүүхийн захиргааны загвар: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам*, 119.

⁷³ Шүүхийн ёс зүйн хорооны 2015.9.17-ны өдрийн 55 дугаар магадлал, 7 дахь талд Хуралдаан даргалагч Н.Эрдэнэцогт, илтгэгч гишүүн О.Мөнхсайхан.

⁷⁴ Мөн тэнд.

⁷⁵ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015.12.10-ны өдрийн 570 дугаар магадлал.

⁷⁶ Улсын дээд шүүхийн 2016.02.15-ны өдрийн 40 дүгээр тогтоол.

хариуцлага хүлээлгэдэг.⁷⁷ “Шүүгчийн хараат бус байдал”, “мэргэжлийн үйл ажиллагаа” зэрэг ойлголтууд нь туйлын шинжтэй биш бөгөөд хуулиар олгосон хараат бус байдлаа урвуулан ашиглахгүй байх хязгаарлалт-хариуцлагын механизмыг тогтоохгүй байж болохгүй. Энэ асуудлыг шийдвэрлэхээр ШЁЗХ жишиг тогтоон хэрэглэж байгаа нь зүйтэй хэдий ч энэ жишиг нь зөвхөн хороон дотор үйлчлэх шинжтэй буюу давж заалдах, хяналтын шатны журмаар шүүхэд хянан шийдвэрлэхэд үйлчлэхгүй учир хангалтгүй. Иймд ШЁЗД-д өөрчлөлт оруулж, шүүгчийн санаатай гаргасан мэргэжлийн алдаа, шууд тодорхой заасан хуулийн заалт, Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрхийг зөрчсөн, ялангуяа удаа дараа зөрчсөн тохиолдолд ёс зүйн зөрчилд тооцдог болгох шаардлагатай.

2.2. Шүүхийн ёс зүйн хорооны бие даасан, гишүүний хараат бус байдал

Шүүхийн ёс зүйн хорооны бие даасан байдал: ШЁЗХ-ны бие даасан байдалтай холбоотой дараах гурван асуудал бий. Нэгд, гишүүдийн томилгоог улс төрийн албан тушаалтан хийдэг, хоёрт, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын төлөөлөлтэй, гуравт, ШЁЗХ-ны үйл ажиллагааны хараат бус байдал зэрэг болно.

Нэг дэх асуудал нь ШЁЗХ-ны гишүүдийг хуульд заасан байгууллагуудаас нэр дэвшүүлэн Монгол Улсын Ерөнхийлөгч томилдог. Ерөнхийлөгч нь тодорхой бүрэн эрхийн хугацаатайгаар сонгогддог улс төрийн албан тушаалтан. Ерөнхийлөгч ШЁЗХ-ны бүх гишүүд, даргыг томилох эцсийн шийдвэрийг гаргаж байгаа нь хороог түүнээс хараат болох нөхцлийг бүрдүүлж байна.⁷⁸ Жишээ нь ийм томилгооны механизм Францад байсан бөгөөд Шүүхийн дээд зөвлөлийг улс төрийн хувьд ихээхэн хамааралтай болгосон гэсэн шүүмжлэл гарч, 1994 оноос нэр дэвшүүлэх эрхтэй этгээдүүд шууд томилох эрхтэй болгосон.⁷⁹

Хоёр дахь асуудал нь шүүгчийн сахилгын хэргийг шийдвэрлэдэг институтын хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус байх явдал. ШЁЗХ нь нийт 9 гишүүнтэйгээс гурван гишүүн буюу бүрэлдэхүүний 30 хувийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилж байгаа нь ШЁЗХ-ны бие даасан байдлын үүднээс авч үзвэл төдийлөн зохистой биш байна. Ялангуяа шүүгчийн сахилгын хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн, чиг үүрэг гэж жигд хуваарилдаггүй⁸⁰ өнөөгийн тогтолцоонд ХЗЯ-ны төлөөлөл нэг сахилгын хэргийг шийдвэрлэхэд олонх болж оролцох боломжтой. Судалгааны 1 дүгээр бүлэгт судалсан зөвлөмж, баримт бичгүүд, АНУ, Польш, Франц зэрэг оронд шүүгчийн сахилгын хэргийг шийдвэрлэхэд Хууль зүйн яам ийм өндөр үүрэгтэй оролцдоггүй.

Гурав дахь асуудал нь ШЁЗХ-ны үйл ажиллагаанд гол төлөв холбогдоно. Шүүгчийн сахилгын институти нь бүрэлдэхүүн, томилгооны хараат бус байдлаас гадна институцийн болон эдийн засгийн хувьд бие даасан, хараат бус байх учиртай. Хуульчдын мэргэжлийн хариуцлагыг сахиулдаг ХМХХ-ны хувьд бие даасан байдлын баталгааг дөрвөн талаас нь хангахаар ХЭЗБТХ

⁷⁷ Cynthia Gray, *How Judicial Conduct Commissions Work*, 405.

⁷⁸ О.Мөнхсайхан, “Монгол Улс дахь шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам,” 25.

⁷⁹ Anja Seibert-Fohr, ed., *Judicial Independence in Transition*, 277.

⁸⁰ Жишээ нь АНУ-д Шүүхийн сахилгын хороог шүүгч, хуульч, иргэд гэсэн 3 талын төлөөллөөс жигд бүрдүүлэх бөгөөд сахилгын хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд аль аль талын төлөөлөл заавал жигд орох шаардлага тавьдаг. Судалгааны ажлын 1.4 дахь хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

болон Мэргэжлийн хариуцлагын хорооны ажиллах журамд тусгасан:⁸¹ 1) бие даасан бүтэцтэй⁸², 2) бие даасан хүний нөөцтэй⁸³, 3) зүй бус нөлөөг хориглосон, 4) бие даасан төсөвтэй⁸⁴ байхаар зохицуулсан бол ШЕЗХ-ны хувьд Ерөнхийлөгчөөс томилогддог хэдий ч ажлын алба нь ШЕЗ-ийн үндсэн бүтцэд харъяалагддаг, дарга, хянан шалгагч нарыг нь ШЕЗ-өөс томилогддог байдал юм.

Бүрэлдэхүүн, гишүүнд тавигдах шаардлага тодорхой биш: ШЕЗХ-ны бүрэлдэхүүн болон гишүүнд тавих шаардлагатай холбоотой дараах хоёр бэрхшээл бий: Нэгд, хуульд заасан “нэр хүндтэй” хуульч, эрдэмтэн, судлаачийг тодорхойлох, хоёрт, бүрэлдэхүүнд шүүгч болон иргэдийн төлөөлөл байхгүй зэрэг болно.

ШЗТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.2-т “Ёс зүйн хороо нэр хүндтэй хуульч, эрдэмтэн, судлаач зэрэг есөн гишүүний бүрэлдэхүүнтэй байна.” гэж заасан. ШЕЗХ-ны 2015-2016 оны бүрэлдэхүүнд их, дээд сургуулийн багш, чөлөөт судлаач 4, төрийн захиргааны байгууллагын удирдах ажилтан буюу төрийн жинхэнэ албан хаагч 3 гээд нийтдээ 7 гишүүн ажиллаж байсан. Эдгээр хүмүүсийн 4 нь эрдэмтэн, судлаач боловч үлдсэн гишүүд нь “төрийн захиргааны албан тушаалтан” байгаа нь хуульд заасан “хуульч, эрдэмтэн, судлаач”-д харъяалагдах эсэх нь эргэлзээтэй. Түүнчлэн хуульд заасан “нэр хүндтэй” гэдэг шаардлагыг тодорхойлох, хэмжихэд төвөгтэй учир үнэн чанартаа ШЕЗХ-нд ямар ч хүн орж ирэх боломжийг улам нэмэгдүүлсэн. Нэр хүндтэй хуульч гэдэг бол хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг гурваас доошгүй жил тасралтгүй явуулсан бөгөөд энэ хугацаандаа мэргэжлийн үйл ажиллагааны зарчим, стандартаа ягштал мөрдөж, үүгээрээ бусад хуульчдадаа хүлээн зөвшөөрөгдсөн байхыг ойлгодог⁸⁵ бол эрдэмтэн судлаач дээр ийнхүү ойлгоход төвөгтэй. Шүүгчдийг шалгаруулах хариуцлагатай ажлыг гардан зохион байгуулдаг Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүний хувьд хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан⁸⁶ гэж заасан байх бөгөөд ийм нарийвчилсан шалгуурыг хуульд тусгайлан оруулах шаардлага гарч байна.

ШЕЗХ-ны бүрэлдэхүүнтэй холбоотой бас нэг бэрхшээл байдаг нь шүүгч, иргэдийн бодит төлөөлөл байдаггүй явдал. ШЗТХ-ийн 32.3-т зааснаар ШЕЗХ-ны бүрэлдэхүүнд шүүгч, ШЕЗ-ийн гишүүн, өмгөөлөгч, прокурор орохыг хориглосон. Олон улсад шүүгчдийн сахилга, ёс зүйн асуудлыг шийдвэрлэх бүрэлдэхүүнд шүүгчдийн төлөөллийг оролцуулахгүй байхыг дэмждэггүй.⁸⁷ Өөрөөр хэлбэл, шүүгчдийн сахилга, ёс зүйн асуудлыг шийдвэрлэхэд шүүгчид

⁸¹ О.Мөнхсайхан “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (2015) батлагдвал хуульчийн мэргэжлийн хариуцлагын тогтолцооны үр нөлөөтэй, хараат бус, шударга байдал алдагдана” *Шүүх эрх мэдэл*, дугаар 3 (2015):3.

⁸² Жишээ нь: Хуульчийн мэргэжлийн хариуцлагын хороо нь өөрийн тогтоосон загвараар үйлдсэн тэмдэгтэй байдаг байна. Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны ажиллах журам”-ын 2.4.1.

⁸³ Мөн тэнд, “МХХ-ны Ажлын албаны дарга, сахилгын шинжээч, шалгагчийг Холбооны зөвлөл 4 жилийн хугацаатай томилдог нь тэдний хараат бус байдлын баталгаа (МХХАЖ, 2.5, 2.6-р зүйлүүд). Сахилгын шинжээч, шалгагчид нэр дэвшүүлэх бүрэн эрхийг Ажлын албаны даргад өгсөн учраас тэрээр энэ албан тушаал дээр хэн ажиллах вэ гэдэгт шийдвэрлэх нөлөөтэй. Ажлын албаны дарга, сахилгын шинжээч, шалгагч бол Хуульчдын холбооны Тамгын газрын ажилчид биш.”

⁸⁴ Мөн тэнд, “Хороо маргааныг цаг алдалгүй шалгах, зөрчлийг нотлох, шийдвэрлэх, мэдлэг ур чадвартай хүмүүсийг сонгон ажиллуулах, ажиллах үр дүнтэй ажиллах орчин бүрдүүлэх санхүүгийн сурвалжтай байна. Ажлын алба өргөдөл гомдлыг шалгах, нотлох баримт бүрдүүлэх, мэдээллийн эх сурвалжийг шалгах зэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд хангалттай ажилтан болон санхүүгийн эх сурвалжтай байна. Энэхүү эх сурвалжийг хангахуйц төсвийг баталж өгөх үүргийг Хуульчдын холбооны зөвлөл хүлээсэн.”

⁸⁵ О.Мөнхсайхан, *Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдвал хуульчийн мэргэжлийн хариуцлагын тогтолцооны үр нөлөөтэй, хараат бус, шударга байдал алдагдана*, 27.

⁸⁶ 2012 оны Шүүхийн захиргааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.

⁸⁷ Судалгааны ажлын 1.4 дэх хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

өөрсдөө оролцох нь гарцаагүй, харин бүрэлдэхүүнд хэрхэн тэнцвэртэй байдлыг хадгалах вэ гэсэн асуудал яригддаг. Манай улсын хувьд гурван шатны шүүгчдийн төлөөлөөс ШЁЗХ-ны өөрсдийн төлөөлөл болгон нэр дэвшүүлж байгаа ч хуулиар шүүгч орохыг хориглосон. АНУ-д жишээ нь шүүгч, хуульч, иргэдийн төлөөлөл гэсэн гурван бүлэгт гишүүдээ хуваарилдаг бөгөөд аль аль талын төлөөллийг тэнцүү хангах зарчим баримталдаг.⁸⁸ Түүнчлэн иргэдийн төлөөллийг оролцуулах нь ШЁЗХ-ны үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналтыг дээшлүүлэх, эцсийн дүндээ шүүхэд итгэх иргэдийн итгэлд эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой. Олон улсад иргэдийн төлөөлөлд төдийлөн ач холбогдол өгдөггүй байсан улс орнууд ч хууль тогтоомждоо өөрчлөлт оруулж иргэдийн хяналтыг нэвтрүүлсэн. Тухайлбал, Франц улсад 2011 оноос Шүүхийн дээд зөвлөлийн бүрэлдэхүүний шүүгч, прокурор биш гишүүдийн тоог нэмсэн.⁸⁹ ШЁЗХ-ны бүрэлдэхүүн, гишүүнд тавигдах шаардлага нь хэдийгээр өмнөх тогтолцоотой харьцуулахад хараат бус, хөндлөнгийн байр суурьтай ажиллах нөхцлийг бүрдүүлсэн боловч шүүгчийн сахилгын хэргийг шийддэг институтын бүрэлдэхүүнд тавигддаг 1) шүүгчдийн төлөөлөлтэй байх, 2) иргэдийн төлөөлөлтэй байх гэсэн зарчмыг алдагдуулжээ. Иймд шүүгч, хуульч, иргэдийн төлөөлөл гэсэн бүрэлдэхүүнтэй байхаар хуульчлах, бүрэлдэхүүнийг улс төрийн албан тушаалтан томилдог байдлыг халж, шат шатны шүүгчдийн зөвлөгөөн, МХХ зэрэг нь шууд томилдог болох зэрэг нь энэ асуудлыг шийдэх арга зам болж болох юм. Ингэхдээ шүүгч, иргэдийн төлөөлөл нь бодит төлөөлөл байх буюу тухайн шатны шүүхийн шүүгч байх, иргэдийн хувьд төрийн албан хаагч бус, жинхэнэ иргэдийн төлөөлөл байх зэрэг асуудлыг анхаарах нь зүйтэй.

Гишүүнд нэр дэвшүүлэхтэй холбоотой бэрхшээл: ШЗТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэгт зааснаар ШЁЗХ-ны гишүүдийг гурван шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тус бүр нэг, МХХ, Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас тус бүр гурван хүнийг нэр дэвшүүлэн Ерөнхийлөгч томилдог. ШТХ-ийн 25.2.7-д ШЁЗХ-ны гишүүнд нэр дэвшүүлэх бүрэн эрхийг шүүгчдийн зөвлөгөөнд олгосон. Шүүгчдийн зөвлөгөөнөөс ШЁЗХ-ны гишүүнийг нэр дэвшүүлэхэд дараах асуудал байна: (1) ШЁЗХ-ны гишүүний сул орон гарсан, бүрэн эрхийн хугацаа дууссан тохиолдолд нөхөн томилох, нэр дэвшүүлэх ажиллагааг хэн, хэдий хугацаанд, хэрхэн зохион байгуулах, санал хураалтыг нэгэн зэрэг хэрхэн явуулах зэрэг хуулийн зохицуулалт байхгүй; (2) Шүүх бүрээс ирсэн нэр дэвшигчдийн үнэлгээ, шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг тухайн шатны хэмжээнд нэгтгэн дүгнэх, Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхтэй холбоотой хуульчилсан зохицуулалт хуульд байхгүй. Жишээ нь ШЁЗХ-ны гишүүнд Монголын Хуульчдын холбооноос нэр дэвшүүлэх процессын зохицуулалт хуульд байхгүй байна. ШЗТХ-ийн 13.1, 32.3-т тус тус заасны дагуу ШЕЗ болон ШЁЗХ-ны гишүүнд нэр дэвшүүлэх чиг үүрэг МХХ-нд байна. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45.1.12-д МХХ нь ШЕЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх чиг үүрэгтэй байхаар зохицуулсан ба ШЁЗХ-ны гишүүнд нэр дэвшүүлэх чиг үүрэг огт тусгагдаагүй. Харин ШЕЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх процессыг⁹⁰ сонгон шалгаруулалтыг зохион байгуулах нэгж, хугацаа, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, санал хураалт явуулах үйл ажиллагаа зэргийг маш тодорхой зохицуулсан. Энэхүү жишгийг баримтлан МХХ-ноос ШЁЗХ-ны гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагааг хуульчлах шаардлагатай.

⁸⁸ Америкийн Хуульчдын холбооноос гаргасан загвар дүрэмд Сахилгын хороо 12 гишүүнтэй байх бөгөөд 4 нь шүүгч, 4 нь иргэн, 4 нь хуульч байхаар тэнцвэрийг хангасан.

⁸⁹ Зөвлөлийн 17 гишүүний 4 нь иргэн байсан бол одоо 6 гишүүн нь иргэн байхаар болсон. Эдгээр иргэдийн хоёрыг Ерөнхийлөгч, хоёрыг Сенатын танхим, хоёрыг Төрийн зөвлөлөөс тус бүр томилдог. Anja Seibert-Fohr, ed., *Judicial Independence in Transition*, 280.

⁹⁰ 2012 оны Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 61 дүгээр зүйл.

2.3. Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Гомдол хүлээн авах, урьдчилан шалгах, сахилгын хэрэг үүсгэх ажиллагаа: Өнөөгийн зохицуулалтаар шүүгчийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдлыг хүлээн авсан даруйд шүүгчид мэдэгддэг. Гэтэл олон улсын түвшинд⁹¹ заавал ийнхүү мэдэгдэх шаардлагагүй гэж үздэг байна. Учир нь нь нэг талаас ёс зүйн зөрчлийг нотлох баримтыг хамгаалах⁹², нөгөө талаас шүүгчийн хувийн хараат бус байдалд нөлөөлөх магадлалтай⁹³ тул сахилгын хэрэг үүсгэж албан ёсоор шалгаж эхлэх хүртэлх урьдчилан шалгах ажиллагаа нууц байж болдог. Манай улсын хувьд ШЕЗХ нь шүүгчийн сахилгын зөрчилтэй холбоотой гомдлыг хүлээн авснаас хойш 2 хоногийн дараа гомдлын үндэслэл нотлогдоогүй байхад шүүгчээс тайлбар авдаг нь шүүгч үндэслэлгүй гомдолд хариу тайлбар өгч үндсэн ажил үүрэг болох шүүн таслах ажиллагаагаа цалгардуулах, зарим тохиолдолд шүүгчид ийнхүү урьдчилан мэдэгдэх нь сахилгын хэргийг нотлоход шаардлагатай шүүх хуралдааны дуу дүрс бичлэг, тэмдэглэл зэрэг нотлох баримт устаж үгүй болох нөхцлийг бүрдүүлж болох юм.

Шүүгчид холбогдуулан сахилгын хэргийг үүсгэхдээ ШЕЗХ нь ШЭЗБТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.2-д зааснаар ирүүлсэн гомдол нэг бүрийг талуудыг оролцуулан заавал хуралдаанаар хэлэлцэж, хянан үздэг. 2015 онд ШЕЗХ нь иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс нийт 284 шүүгчид (давхардсан тоогоор) холбогдох 213 гомдол хүлээн авснаас зөвхөн 31 шүүгчид сахилгын хэрэг үүсгэн шийдвэрлэжээ.⁹⁴ Энэ нь дунджаар нийт хянан хэлэлцсэн гомдлын 12 хувь, шүүгчийн 10 хувьд нь сахилгын хэрэг үүсгэсэн байна. Эндээс шүүгчид холбогдуулан сахилгын хэрэг үүсгэх ажиллагаа хэт нүсэр, шүүгч болон гомдол гаргагчийг чирэгдүүлсэн, нийтлэг жишигт байхгүй зохицуулалт болсон гэсэн дүгнэлт хийж болох бөгөөд доктор О.Мөнхсайханы гаргасан “Одоогийн хуулийн хүрээнд талуудыг оролцуулсан хуралдаан хийлгүйгээр гурван гишүүн сахилгын хэрэг үүсгэх эсэхийг зөвлөлдөж шийдвэрлэх боломжтой”⁹⁵ гэсэнтэй санал нэг байна.

ШЕЗХ-нд мөрдөн шалгах болон санаачилгаараа хэрэг үүсгэх, шалгах эрх хэмжээ байхгүй: ШЕЗХ-ны гомдол хүлээн авсан гишүүн шаардлагатай гэж үзвэл ажлын албаны ажилтнаар баримт, мэдээлэл, бүрдүүлэх даалгавар бүхий захирамж гаргадаг. ШЕЗХ-ны гишүүн энэ шалгах чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлэх, ямар бүрэн эрх эдлэх талаар хуульчлаагүй.⁹⁶ Гэрчээс хууль сануулж тайлбар авах, аливаа этгээдээс нотлох баримт гаргуулах, шинжээч томилох зэрэг бүрэн эрх ШЕЗХ-ны гишүүн эсхүл ажлын албанд байхгүй учраас шүүгчийн эсрэг гарсан гомдлыг бүрэн

⁹¹ Тухайлбал, Шүүгчийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын суурь зарчмуудын 17 дугаар зарчим, Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тунхагийн 15 дугаар зүйлд сахилгын хэрэг үүсгэхээс өмнөх шатанд шүүгчид урьдчилан мэдэгдэх, олон нийтэд нээлттэй болгох шаардлагагүй гэж заажээ.

⁹² Жишээ нь иргэнээс шүүгч шүүх хуралдааны явцад зохисгүй үг хэллэг хэрэглэсэн тухай гомдол иржээ. Монгол Улсын нийт шүүхийн шүүх хуралдаанд дуу-дүрс бичлэгийн төхөөрөмж байрлуулсан бөгөөд шүүгчийн ёсзүйн зөрчлийг тогтоохын тулд тухайн хуралдааны бичлэг шаардлагатай болно. Шүүгчид сахилгын хэрэг үүсгэхийн өмнө ийнхүү мэдэгдсэнээр тухайн өдрийн хуралдааны бичлэг уствал сахилгын хэргийг нотлоход улам төвөгтэй болно.

⁹³ Шүүгчид мэдэгдэхгүй шалгах нь шүүгчийн хараат бус байдал, шүүн таслах бусад ажиллагааных нь хэвийн нөхцлийг бүрдүүлэх зорилготой. Шүүхийн шийдвэрт сэтгэл ханамжгүй үлдсэн эсвэл ялагдах магадлалтай тал нөлөөлөхийг оролдсон, шүүгчийг хашраах зорилготой, хувийн сэдэлттэй зэрэг үндэслэл шаардлагагүй гомдлыг урьдчилан тогтоож, шаардлагагүй ачаалал үүсгэхээс, шүүгчид үндэслэлгүй дарамт учруулахаас сэргийлэх “шүүлтүүрийн үүрэг” гүйцэтгэдэг.

⁹⁴ О.Одгэрэл, С.Билгүүн, Монгол Улсын шүүхийн тайлан (УБ: Мөнхийн үсэг, 2015), 55.

⁹⁵ О.Мөнхсайхан, Монгол Улс дахь шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам, 35.

⁹⁶ Мөн тэнд.

шалгах боломж хязгаарлагдмал.⁹⁷ Олон улсад шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх институтэд нотлох баримт цуглуулах, гэрчийг байцаах зэрэг ажиллагаанд *subpoena* буюу албадлага хэрэглэх боломжийг бүрдүүлэх ёстой гэж үздэг.⁹⁸ Шүүгчийн сахилгын хэргийг шалгаж, хангалттай нотлохгүйгээр сэжиг таамаг төдийхөнд буруутгах эсхүл нотлох баримт цуглуулж чадахгүй үндэслэлээр хариуцлагаас бултуулахын аль аль нь байж таарахгүй. Иймд ШЗТХ болон бусад хуулиар нотлох баримт гаргуулан авах, гэрчээс хууль сануулж мэдүүлэг авах зэрэг зохицуулалтыг тусгах зайлшгүй шаардлагатай.

Мөрдөн шалгах эрх хэмжээнээс гадна ШЁЗХ зөрчлийг зөвхөн гомдлын хүрээгээр бус, өөрийн санаачлагаар шалгах эрхгүй байна. Энэ асуудалтай холбоотой дор дурьдсан сахилгын хэрэг 2014 онд шийдвэрлэгдсэн байна:

*Шүүгч У нь “А” аймаг дахь Төрийн банкинд холбогдогдох хэргийг нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх явцад түүний нөхөр хугацаа хэтэрсэн /2010-2014 онд/ зээлийн үлдэгдэл болох нийт 66,713,790.23 төгрөгийг тухайн Төрийн банкинд төлсөн нь нотлох баримтаар нотлогдсон. 2014 оны хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлтөд өөрийн нөхрийн 66,713,790.23 төгрөгийн зээл төлөлтийн талаар бүртгүүлээгүй байх бөгөөд ийнхүү бүртгүүлээгүй гэдгээ тайлбартаа хүлээн зөвшөөрсөн. Ёс зүйн зөрчилд ШЁЗХ Авилгын эсрэг хууль болон Шүүгчийн ёс зүйн дүрмийн дагуу “огцруулах” сахилгын шийтгэлийг оногдуулсан. Харин ЗХДЗШШ, УДШ-ийн Захиргааны хэргийн танхимаас “Шүүхийн ёс зүйн хорооны дарга, гишүүдийн бүрэн эрхийг заасан бөгөөд гомдолд дурдсанаас үл хамааран шалгаж, зөрчил гарсан нь тогтоогдвол шийтгэл хүлээлгэх үүрэгтэй” гэж хууль, дүрмээр олгогдоогүй эрх, үүргийг өөртөө бий болгож, гомдолд дурьдагдаагүй, гомдлын шаардлагаас өөр асуудлаар дүгнэлт хийж, хэргийг шийдвэрлэсэн нь буруу байна гэж үзэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон.*⁹⁹

Шүүгчийн ёс зүйн зөрчлийн объект нь хувийн ашиг сонирхол гэхээс илүүтэй нийтийн ашиг сонирхол бөгөөд маргааны талуудад нотлох үүрэг хүлээлгэдэг хувийн эрх зүйн маргаан биш, харин нийтийн ашиг сонирхол хөнддөг нийтийн эрх зүйн маргаан¹⁰⁰ тул хүрээ нь гомдлын хүрээгээр хязгаарлагддаггүй. Гэтэл манай хууль болон дүрмийн зохицуулалтаар хуульд хариуцлага хүлээлгэхээр заасан зохицуулалт, ШЁЗД-ийг ноцтой зөрчсөн нь нотлох баримтаар бүрэн нотлогдсон байхад “гомдолд дурьдаагүй” гэсэн үндэслэлээр сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож, зөрчил гаргасан шүүгчид хариуцлага хүлээлгэхгүй байгаа нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлд халтай. Эндээс үзвэл Ёс зүйн хорооны шалгах ажиллагаа хувийн эрх зүйн

⁹⁷ Мөн тэнд, 122.

⁹⁸ Жишээ нь Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тунхаглал, Европын шүүхийн зөвлөлүүдийн сүлжээнээс гаргасан баримт бичигт “шүүгчийн ёс зүйн зөрчлийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй субъект нь бие даасан байх ёстой бөгөөд бичгэн болон аман нотлох баримт цуглуулж хэрэгт авах зэрэг боломжтой байх ёстой”⁹⁸ гэж заасан бол Франц, Польш зэрэг оронд шүүгчийн сахилгын хэргийг шалгахад эрүүгийн процессын хэм хэмжээ үйлчилдэг, АНУ-д шаардлагатай нотлох баримтыг гарган өгөөгүй, эсхүл гэрч худал мэдүүлэг өгсөн бол эрүүгийн хариуцлага хүлээхээр зохицуулсан байдаг. European Network of Councils for the Judiciary, Minimum Judicial Standards V: Disciplinary Proceedings and Liability of Judges, 28.

⁹⁹ Шүүхийн ёс зүйн хорооны 2014.9.05-ны өдрийн 45 дугаар магадлал.

¹⁰⁰ О.Мөнхсайхан нар, *Монгол Улс дахь шүүхийн захиргааны загвар: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам*, 124.

маргаан шиг гомдлын хүрээгээр хязгаарлагдахгүй¹⁰¹ байх нь зүйтэй. Мөн одоогийн тогтолцоонд нэг талаас ШЕЗХ-ны гишүүн шалгах чиг үүрэгтэй боловч нөгөө талаас гомдлоо тодорхой хэмжээнд нотлохыг гомдол гаргагчид шууд бусаар үүрэгжүүлдэг. Гэвч шүүгчийн ёс зүйн маргаангомдол гаргагч, шүүгч хоёр нь зөрчил гаргасан эсэх талаар маргалдахаас илүү, төрийн тусгай албан тушаалтан болох шүүгчийн зөрчил гаргасныг шалгахыг шаардаж буй харилцаа юм.

Шалгах, нотлох, хяналт тавих, шийдвэрлэх гэсэн чиг үүргийг хуваарилаагүй: ШЕЗХ-ны гишүүн нь сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэргийг шалгах, сахилгын хэргийг шийдвэрлэх гэсэн гурван чиг үүргийг нэг дор хэрэгжүүлж байна. Олон улсын зөвлөмж, сайн туршлагыг авч үзвэл, наад зах нь ёс зүйн зөрчлийг шалгах, хянан шийдвэрлэх чиг үүргийг өөр өөр субъект хэрэгжүүлэх ёстой гэж үздэг. Тухайлбал, Польшид сахилгын төлөөлөгч сахилгын хэргийг шалгаж, сахилгын шүүх шийдвэрлэдэг бол АНУ-ын Канзас мужид ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх гэсэн чиг үүргээр нь хуваадаг, аль нэг бүрэлдэхүүнд орсон гишүүн нөгөө бүрэлдэхүүнд орохыг хориглодог. Энэ нь шүүгчийн ёс зүйн зөрчлийг шалгасан гишүүн шүүгчийн буруугийн талаар төсөөлөлтэй болсон (knowledge) байх бөгөөд тухайн хэргийг шийдвэрлэвэл шүүгчийг хэт буруутгах эсхүл өмөөрөх зэргээр төвийг сахисан байж чаддаггүй. Монгол Улсын хувьд ШЕЗХ-ны чиг үүргийн хуваарилалтыг хийх хоёр арга зам байна. Нэгдүгээрт, тухайн гомдлыг шалгасан, сахилгын хэргийг үүсгэсэн гишүүд нийт гишүүдийн хуралдаанд оролцохгүй байх хязгаарлалт тавих. Хоёрдугаарт ШЕЗХ-ны бүрэлдэхүүнийг хуулиар 1) мөрдөн шалгах, 2) хянан шийдвэрлэх гэсэн хоёр хэсэгт хуваах саналыг дэвшүүлж байна.

Эхний хувилбарын хувьд хэрэгжихэд гишүүдийн тооноос хамааралтай хүндрэл гарна. ШЕЗХ нийт 9 гишүүний орон тоотойгоос сахилгын хэрэг үүсгэх буюу гомдол хянан хэлэлцэх хуралдаан 3 гишүүний бүрэлдэхүүнтэй явагдах бол нийт гишүүдийн хуралдаан гишүүдийн олонхийн ирцтэй явагдах ёстой. Нийт 9 гишүүнээс дор хаяж 3 гишүүнийг сахилгын хэргийг шийдвэрлэх хуралдаанд оролцохыг хязгаарлах бөгөөд үлдсэн 6 гишүүн хурлаа хийх хууль зүйн боломж байгаа хэдий ч практикт ийм боломж хомс. 2013 оноос хойш ШЕЗХ бүрэн бүрэлдэхүүнээрээ ажилласан тохиолдол бараг үгүй бөгөөд өнөөдрийн байдлаар 7 гишүүнтэй ажиллаж байна.

Хоёр дахь хувилбарын хувьд мөрдөн шалгах бүрэлдэхүүн нь гомдол, ажлын албаны хянан шалгагчийн цуглуулсан баримтан дээр үндэслэж сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх, хянан шалгах ажиллагаа бүрэн гүйцэд явагдсан бол сахилгын шийтгэлийн саналыг баталж, хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд шилжүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх бол хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн сахилгын хэргийг хүлээн авч эцэслэн шийдвэрлэх чиг үүрэгтэй болно. Хорооны гишүүдийг мөрдөн шалгах (3 гишүүн), хянан шийдвэрлэх (6 гишүүн) гэж хувааж болох боловч Хорооны үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангах зорилгоор бүрэлдэхүүн тус бүр 1-2 гишүүний “нөөц”-тэй байх ёстой. Эндээс үзвэл ШЕЗХ-ны гишүүдийн тоог дор хаяж 12-15 болгон нэмэгдүүлэх шаардлага зайлшгүй гарч байна.

Шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэсэн магадлалд давж заалдах: ШЕЗХ 2015 онд 13 шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан 14 магадлалын 9 магадлалыг ЗХДЗШШ-ээс “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүгчийн мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй гэснийг зөрчсөн дүгнэлт гаргасан”

¹⁰¹ Судалгаанд хамруулсан Польш, Франц, АНУ-д гомдлын хүрээгээр хязгаарлах зохицуулалт байхгүй тухай нэгдүгээр бүлэгт авч үзсэн. Мөн сахилгын хэргийг өөрийн санаачилгаар үүсгэх боломжийг олгосон. Энэ нь шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь талуудын санаачилгаар үүсдэг хувийн эрх зүйн маргаан биш, харин түүнийг нийтийн эрх ашгийн өмнөөс шалгадаг, шийдвэрлэдэг гэсэн үзэл баримтлалыг харуулж байна.

гэсэн үндэслэлээр хүчингүй болгож, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. 3 магадлалыг мөн дээрх үндэслэлээр дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэжээ. Судалгаанаас харахад шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан ШЕЗХ-ны 14 шийдвэрээс 13 шийдвэрийг ЗХДЗШШ, УДШ-ээс хүчингүй болгосон нь ШЕЗХ-ны шийдвэрийн тогтвортой, үр нөлөөтэй байдалд эргэлзээ төрүүлж байна. ШЕЗХ-ны магадлалыг давж заалдахтай холбоотой хоёр үндсэн асуудал байна. Нэгд, ШЕЗХ-ны шийдвэр шүүхийн шатанд хүчингүй болж байгаа нь шүүгч шүүгчээ хамгаалах явцуу ашиг сонирхолтой холбоотой эсэх, хоёрт, ШЕЗХ-ны шийдвэрт давж заалдах, хяналтын шатны журмаар гомдол гаргах боломжийг бүрдүүлсэн нь оновчтой эсэхийг тогтоох шаардлагатай.

Эхний асуудлын хувьд шүүгчид оногдуулсан сахилгын шийтгэлийг хүчингүй болгосон үндэслэлийн 11 нь шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны алдаа учир ШЕЗХ харьяалан шийдвэрлэх эрхгүй, 2 нь хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэл байжээ. ШЕЗХ-ны шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан үндэслэлүүдийг¹⁰² харахад хэргийн оролцогчдын эрхийг хангаагүй, хуульд заасан ажиллагааг илт болон удаа дараа зөрчих гэсэн нийтлэг зөрчил ажиглагдаж байх бөгөөд энэ асуудал нь өгүүллийн 2.1 дэх хэсэгт авч үзсэн Шүүгчийн ёс зүйн дүрмийн холбогдох заалтыг өөрчлөх замаар шийдвэрлэгдэнэ.

Харин хоёр дахь асуудлын хувьд маргаантай. ШЕЗ-өөс 2016 онд зохион байгуулсан “Шүүгчийн ёс зүй ба хариуцлага” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр дараах саналууд гарч байсан байна.

(1) Одоогийн байдлаар бол ШЕЗХ-нд хариуцлага тооцдог ихэнх нь шүүх дээр очоод хэрэгсэхгүй болдог чиг хандлагатай байна. шүүхийнхээ хяналтад зориуд аваачаад шүүгч нар нь шүүгч нараа өмгөөлж хамгаалаад хариуцлага тооцож чадахаа байчихлаа гэдэг олон нийтийн хардлага хүчтэй байна. Тийм учраас ёс зүйн хорооны доторх хяналт механизмыг илүү нарийн болгож, эрх зүйн орчныг нь сайн болгоод ШЕЗХ-ны шийдвэр эцсийн байдаг чиг хандлагатай болоход болохгүй зүйл байхгүй гэж бодож байна.¹⁰³

(2) Олон улсын конвенцод заасан давах эрх гэдэг бол нэг удаа л давах гэж ойлгож байдаг. Заавал гурван удаа давна гэсэн ойлголт байхгүй. Манайд болохоор буруу ойлгоод заавал дээд шүүх хүртэл нь бүх шатаар явна гэж үзээд байдаг. Ёс зүйн асуудал дээр ямар ч байсан давж заалдах эрхийг нь хангасан шат байх нь зайлшгүй. Тэр нь харин шүүх байх уу? эсвэл илүү өргөтгөсөн бүрэлдэхүүн байх уу? гэдэг дээр судалгаа хийж харах хэрэгтэй.¹⁰⁴

Олон улсын баримт бичиг, загвар дүрмүүд, судалж буй улсуудад давж заалдах эрхийг ихэвчлэн шүүгчид олгосон байдаг ба давж заалдах эрхийн шат нэг байх нийтлэг жишиг байна. Манай улсын хувьд давж заалдах нэг шат байсан нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээс шалтгаалан УДШ хянах болж хоёр болсон нь сахилгын шийтгэл эцэслэн шийдэгдэхгүй байх, шүүгчид шүүгчдээ хамгаалах нөхцөл үүсч байна гэсэн олон нийтийн хардалтыг бий болгох эрсдэлтэй байна. Тиймээс нийтлэг жишигт үндэслэн давж заалдах эрхийг нэг шат байхаар тэр тусмаа шүүгчийн сахилгын институтэд эцэслэн шийдвэрлэгддэг байхаар өөрчлөлт оруулах эсхүл шүүх дээр хамгийн ихээр хүчингүй болж байгаа үндэслэл болсон мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчлийн зааг ялгаа, хөөн хэлэлцэх хугацааг ШЕЗД-д бодитой тогтоох нь зүйтэй.

¹⁰² 2015 оны Шүүхийн ёс зүйн хорооны шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан магадлалын тойм судалгааны дэлгэрэнгүйг хавсралт 4-т үзүүлэв.

¹⁰³ “Шүүгчийн ёс зүй ба хариуцлага” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр Н.Лүндэндорж, хэлэлцүүлгийн тэмдэглэл, www.judoinstitute.mn, 2016 оны 4 сарын 26-нд үзсэн.

¹⁰⁴ Мөн тэнд, О.Мөнхсайхан.

Мөн шүүгчийг огцруулах шийтгэлийг ШЁЗХ эцэслэн гаргаж байгаа нь төдийлөн зохимжгүй байж мэдэх юм. Учир нь аливаа халах, огцруулах, чөлөөлөх зэрэг хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгосон шийдвэрийг томилох эрх бүхий албан тушаалтан гаргадаг гэдэг энгийн логикийг бодож үзвэл ШЁЗХ огцруулах шийтгэлийг өөрөө оногдуулах бус, харин тийнхүү оногдуулахаар зөвлөмж гаргаж холбогдох албан тушаалтанд нь хүргүүлэх, тэрхүү албан тушаалтан, байгууллага нь шалтаг, шалтгаан заалгүйгээр ШЁЗХ шийдвэрийг биелүүлдэг журамд шилжих нь оновчтой.

Дүгнэлт

Энэ өгүүллийн хүрээнд шүүгчийн сахилгын процессын ойлголт, ач холбогдол, түүнийг хэрэгжүүлдэг загварууд, сахилгын процессын үндсэн ажиллагаа, тэдгээрийн нийтлэг жишиг, Монгол Улс дахь шүүгчийн сахилгын процесст тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж шийдвэрлэх гарц арга замыг эрэлхийлэв.

Шүүгчийн сахилгын хэргийг шийдвэрлэх харьяаллын хүрээнд

ШЁЗД, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийн цөөнгүй заалт хоорондоо давхцаж, хууль зүйн тодорхойгүй байдал үүсгэв. Энэ нь зөвхөн материаллаг хэм хэмжээний давхардлаас хальж, шүүгчийн гаргасан зөрчлийг ШЁЗХ шалгах уу, ХМХХ шалгах уу гэсэн маргааны харьяаллын давхардлыг бий болгосон. Мөн шүүгчийн ёс зүйн зөрчилд хамаарах мэргэжлийн алдааг ШЁЗХ-ны харьяаллаас хавтгайруулан гаргасан нь тус хорооны харьяаллыг хязгаарлаж, улмаар шүүгчийн хууль тайлбарлах, процессыг удирдах хүрээнд гаргасан ёс зүйн ноцтой зөрчилд хариуцлага хүлээлгэх механизм байхгүй болжээ.

Шүүхийн ёс зүйн хорооны бүрэлдэхүүн, бие даасан байдлын хүрээнд

2012 оны ШЗТХ-иар сахилгын хэрэг шалгах, шийдвэрлэх субъектын бүрэлдэхүүний зайлшгүй шаардлага болсон шүүгч, иргэдийн төлөөллийг орхисон. Улс орнууд шүүгчдийн асуудлыг шийдвэрлэхэд шүүгчдийн бодит төлөөлөл оролцдог, түүнд иргэдээс тавих хяналт зайлшгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, бүрэлдэхүүний тэнцвэрийг хэрхэн хангах вэ гэдэгт анхаардаг. Олон улсын жишиг стандартаар шүүгчийн сахилгын асуудлыг шийдвэрлэж байгаа субъект хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс төдийгүй шүүхийн захиргааны байгууллага, шүүхээс өөрөөс нь бие даасан байх шаардлага тавигддаг. Гэтэл Монгол Улсад ШЁЗХ нь орон тооны бус шинжтэй, ажлын алба нь өөр субьектэд харьяалагддаг, бүрэлдэхүүнийг төрийн улс төрийн албан тушаалтан томилдог, гишүүдийн чиг үүргээ хэрэгжүүлэх баталгааг хуульчлаагүй, дээрээс нь бүрэлдэхүүний гуравны нэгийг гүйцэтгэх эрх мэдлээс бүрдүүлсэн зэрэг нь хорооны эрх зүйн байдлыг дахин авч үзэж боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна.

Шүүгчийн сахилгын хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх, давж заалдах хүрээнд

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын ШЁЗХ-ны дүрмийн зохицуулалтыг ажиглавал сахилгын процесс нь талуудын сайн дурын санаачлагад тулгуурласан нь харагдаж байна. Иргэнээс гомдол ирсэн даруйд нөгөө тал буюу шүүгчид мэдэгддэг, сахилгын хэрэг үүсгэхэд шүүгчийг заавал оролцуулдаг, нотлох чиг үүргийг тусгай субьект бус, гомдол гаргагч иргэн хүлээдэг, ШЁЗХ өөрийн санаачлагаар зөрчил шалгадаггүй, зөвхөн гомдлоор хязгаарлагддаг зэрэг нь сахилгын процессын нийтлэг жишигтэй төдийлөн нийцэхгүй байгаа юм. Мөн хуулиар ШЁЗХ-нд сахилгын хэрэгт хамааралтай баримт сэлт цуглуулах, гэрчээс мэдүүлэг авах зэрэг зөрчлийг шалгаж тогтооход зайлшгүй шаардлагатай эрх хэмжээг олгоогүй

нь шүүгчийн гаргасан ёс зүйн зөрчлийг бодитой тогтооход бэрхшээл учруулж байна. Цаашлаад ШЁЗХ-ны бүрэлдэхүүний дотоод чиг үүргийн хуваарилалтыг хийгээгүйгээс шүүгчийн сахилгын хэргийг шийдвэрлэхэд өмнө нь тухайн хэргийг шалгаж, нотолсон гишүүн таслах эрхтэй оролцдог. Энэ нь процесс шударга байх, хараат бус, төвийг сахисан субъект сахилгын хэргийг шийдвэрлэх жишгийн үүднээс авч үзвэл оновчтой биш. Түүнчлэн ёс зүйн материаллаг хэм хэмжээний оновчгүй зохицуулалт, процессын зөрчлөөс үүдэлтэйгээр ШЁЗХ-ны шийдвэр тогтвортой байдал алдагдсан нь энэ чиглэлд цаашид анхаарах ёстойг харуулж байна.

Санал

Судалгааны хүрээнд тодорхойлсон жишиг шалгуур, олон улсын туршлага, Монгол Улс дахь сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт тулгуурлан дараах 3 бүлэг саналыг дэвшүүлж байна.

Шүүгчийн сахилгын хэргийг шийдвэрлэх харьяаллын хүрээнд:

- Шүүгчийн ёс зүйн дүрэм, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрэм хоорондын давхцлыг арилгах. Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг зөвхөн шүүгчид хамаарах ёс зүйн дүрмээр тогтоох,
- Шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шалгах, шийдвэрлэх харьяалал, ёс зүйн зөрчилд хамаарах мэргэжлийн алдааг тодорхой хуульчилж, хянан шийдвэрлэх харьяаллыг ШЁЗХ-нд бүрэн өгөх.

Шүүхийн ёс зүйн хорооны бүрэлдэхүүн, бие даасан байдал, чиг үүргийн хүрээнд:

- Шүүхийн ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд шүүгч, хуульч, иргэдийн төлөөллийг оролцуулах. Ийнхүү оролцуулахдаа аль нэг төлөөллийг олонхи болгохгүй, тэнцвэрийг хангах;
- Ёс зүйн хорооны бие даасан байдлыг хангахын тулд гишүүнд нэр дэвшүүлэх, томилох зэрэг ажиллагаанд улс төрийн болон бусад эрх мэдлийн оролцоог багасгах;
- Хороо бие даан үйл ажиллагаа явуулах нөхцлийг хуульчлах, хүний нөөц, төсөв, институт, үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах;

Шүүгчийн сахилгын хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх хүрээнд:

- Шүүгчид сахилгын хэрэг үүсгэхийн өмнө буюу гомдол мэдээлэлд холбогдсон шүүгчид мэдэгдэхээс өмнө урьдчилсан ажиллагаа хийж, нотлох баримтыг хөдөлбөргүй бэхжүүлж авах боломжийг бүрдүүлэх. Гомдол ирсэн даруйд бус, сахилгын хэрэг үүсгэсэн даруйд шүүгчид мэдэгддэг, мэтгэлцүүлдэг болох;
- Ёс зүйн хорооны зөрчил шалгах ажиллагаа гомдлын хүрээгээр хязгаарлагдахгүй байх зарчмыг хуульчилж тогтоох;
- Шүүхийн ёс зүйн хороонд мөрдөн шалгах шаардлагатай эрх хэмжээг хуулиар олгох, хэрэгжих баталгааг нь хуульчлах;
- ШЁЗХ-ны бүрэлдэхүүнийг мөрдөн шалгах, шийдвэрлэх гэсэн бүрэлдэхүүнд хуваарилж, сахилгын хэргийг шалгасан гишүүн тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд оролцохгүй байх нөхцлийг бүрдүүлэх
- ШЁЗХ-ны магадлал хүчингүй болж байгаа гол үндэслэл болсон мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчил хоорондын зааг ялгаа, хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг шүүгчийн ёс зүйн дүрмээр оновчтой зохицуулах замаар ШЁЗХ-ны шийдвэрийн тогтвортой байдлыг хангах, цаашдаа давж заалдах эрхийг нэг шат байхаар, тэр тусмаа хараат бус

хөндлөнгийн бие даасан шүүгчийн сахилгын институтэд эцэслэн шийдвэрлэх хувилбарыг судалж нэвтрүүлэх шаардлагатай байна.

